МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР**

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай 3, Утас: 26 02 03,
Факс: (976-11) 32 26 83, И-мэйл: info@gazar.gov.mn

2023.12.19 № 1/2783

танай ____________-ны №____________-т

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМАНД

Тус газрын чиг үүргийн хүрээнд хяналтад авч хэрэгжүүлж буй Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар гарган хүргүүлж байна.

Хавсралт 34 хуудастай.

ДАРГА А.ЭНХМАНЛАЙ

9128821 1117149041

1523022804

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын
даргын 2023 оны 12 дугаар сарын
19-ны өдрийн 1770 дугаар албан бичгийн хавсралт

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ
/2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/

2023 оны 12 дугаар сарын 19 Улаанбаатар хот

| д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Хэрэгжилтийн явц | Үнэлгээ, (хүчин гүй болсон, хяналтаас хасуулах тухай санал) | Тасарсан болон удаашириж байгаа шалтгаан |
|---|---|---|---|---|
| 1 | 3 | 4 | 5 | 6 |
| **Ерөнхийлөгчийн зарлиг** | | | | |
| 1 | 2021.08.25 №39<br>“Ажлын хэсэг байгуулах тухай” | Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дугаар 39 захирамжаар батлагдсан “Уур амьсгалын өөрчлөлт, түүний хор уршиг, нөлөөлөл болон цөлжилтийг бууруулах талаар санал дүгнэлт боловсруулах чиглэлд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүн.<br>**Хэрэгжүүлж байгаа ажлын талаарх танилцуулга**<br>- Тус газраас бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг 2022 онд бэлчээрийн газрын мониторингийн 5166 цэгт хийсэн ба Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс бэлчээрийн мониторингийн 1513 цэгийг мэдээг авч нэгтгэн нийт 6679 цэгт дүн шинжилгээ хийж, бэлчээрийн газрын төлөв байдлын зургийг боловсруулж нөхөн сэргээх талбайг тодорхойлсон. Гарсан үр дүнг санал, дүгнэлтийн хамт Нийслэлийн газар зохион байгуулалтын алба болон 21 аймгийн ГХБХБГазарт болон БОАЖЯаманд 1/2132, ХХААХҮЯаманд 1/2121 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>- Нийслэлийн мониторингийн 300 цэгт бохирдлын судалгааны ажлыг хийж гүйцэтгэн материал боловсруулалтын ажил хийгдэж байна. Тариалангийн газрын мониторингийн 100 цэгт хянан баталгааны ажлыг хийж гүйцэтгэн үр дүнг ашиглан “Зайнаас тандан судлалын аргаар тариалангийн газрын мониторинг хийх аргачлал”-ын төслийг боловсруулж холбогдох хурлуудаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.<br>- Хөрсний хяналт-шинжилгээний лаборатори байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн зөвлөлийн гишүүдээс гарсан саналыг тусган Барилга, хот байгуулалтын яаманд 1/1869 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>- Газрын мониторингийн үндэсний сүлжээг өргөжүүлж, бусад байгууллагатай хамтран дундын мэдээллийн сан үүсгэх салбар дундын оролцоог хангах хэлэлцүүлгийг 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулж, холбогдох байгууллагуудаас гарах | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | мэдээллүүдийг нэгтгэн цаашид нэгдсэн дундын мэдээллийн санг үүсгэж мэдээлэл солилцох, холбох ажлыг хэрэгжүүлэхээр БХБ-ын дэд сайдаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулахаар ажиллаж байна.<br>- Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг бий болгож, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор "Газрын мониторингийн цахим системд шаардлагатай нэмэлт хөгжүүлэлт хийх" ажлыг "Софт мастер" ХХК-тай гэрээ байгуулан 2022 оны 09 дүгээр сараас нэмэлт хөгжүүлэлт хийж 12 дугаар сарын 20-ны дотор хүлээж авахаар ажиллаж байна. | | |
| **<u>Улсын Их Хурлын тогтоол</u>** | | | | |
| 1 | 2022 оны 36 дугаар Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай | Монгол улсын Их хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 36 дугаар Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоол батлагдаж 2022 оны 09 дүгээр сарын 06-ний өдөр арга хэмжээний төлөвлөгөөг иргүүлсэн.<br>Тус тогтоолын хавсралтын 3.1 дэх хэсэгт заасан "Тариалангийн зориулалттай газар ашиглалтыг сайжруулах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор шинээр 200.0 мянган гектар хүртэл атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх, эргэлтийн талбайг 1.1 сая гектарт хүргэх, усалгаатай тариалангийн талбайн 5.0 мянган гектараар нэмэгдүүлэх, тариалангийн газрыг улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэх" ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тооцож, 2023 оны улсын төсөвт суулгах саналыг 2022 оны 09 дүгээр сарын 09-ний 1/1751 тоот албан бичгээр Барилга хот байгуулалтын сайдад хүргүүлсэн.<br>Энэхүү ажлын хүрээнд ашиглалтгүй байгаа атаршсан газрыг аж ахуйн эргэлтэд оруулах 211'573.3 га, хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон тариалан болон атаршсан газарт нөхөн сэргээлт хийх 8021 га, усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх 5 га, нийт 219'599.3 га талбайг аж ахуйн эргэлтэд оруулах төлөвлөгөөг батлуулан газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 1/1864 тоот албан бичгээр чиглэл хүргүүлсэн. | 100 | |
| 2 | 2021 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 106 дугаар тогтоол "Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай" хавсралт 2 | **1.1.1** Боомтуудыг хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг тодотгох, шинээр нэмж боловсруулах замаар боомтуудын хөгжлийг хөрш орнуудын боомттой ижил түвшинд хүргэж, дэд бүтэц, тээвэр зохион байгуулалтыг олон улсын стандартад нийцүүлэх:<br>**Хэрэгжилт:** 23 хилийн боомтоос ерөнхий төлөвлөгөө боловсруулагдан Монгол Улсын Хилийн Боомтын Үндэсний зөвлөлөөр Ханх, Алтанбулаг, Бичигт, Замын-Үүд, Ханги, Булган зэрэг 6 боомт, Монгол Улсын Засгийн Газраар батлуулсан Боршоо, Гашуун Сухайт, Шивээхүрэн 3 боомт батлуулсан. "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-д Замын-Үүд, Гашуун Сухайт, Алтанбулаг хилийн боомтын ерөнхий төлөвлөгөөг оруулсан.<br>Хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн байдлын судалгааг гаргаж, ерөнхий төлөвлөгөөний зураглал материал, баримт бичгийн иж бүрдлийг цуглуулах ажлын хүрээнд Гаалийн ерөнхий газрын Боомтын хөгжлийн газарт 2022 оны 1/1675 дугаар албан бичгийг хүргүүлэн, хамтран ажилласан. | 100 | |

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд 11 хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг үүсгэж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Үүнд:

1. Алтанбулаг боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө
2. "Боршоо" хилийн боомтын өргөтгөл, шинэчлэлтийн зураг-Ерөнхий төлөвлөгөө өөрчлөлт
3. Гашуун сухайт хилийн боомтын ерөнхий төлөвлөгөө
4. Замын-Үүд хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө
5. Бичигт хилийн боомтын ерөнхий төлөвлөгөөний тодотгол
6. Булган хилийн боомтын ерөнхий төлөвлөгөө
7. "Шивээхүрэн" хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө
8. Ханги хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө
9. Ханх хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө
10. Зэлтэр хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө
11. Бургастай хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

**2.1.7.** Төв аймгийн Хөшигийн хөндийд шинэ дагуул хотууд болон эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэхэд шаардлагатай дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэрийг шийдвэрлэх:

**Хэрэгжилт:** Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлыг зураг эцэслэн батлагдаж улсын төсөвт 30 гаруй тэрбум төгрөг тусгагдаж таван худгаас инженерийн шугам сүлжээн татах, 35 кВт-ын цахилгаан шугам сүлжээний ажлыг эхлүүлсэн. Инженерийн шугам сүлжээний хамгааллалтын зурвасыг "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-д оруулж мэдээллийн санг баяжуулсан. Хөшигийн хөндийн суурьшлийн бүсийн шинэ хотуудыг хэрэглээг хангах зорилгоор Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 12, 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй Баруун эх үүсвэрээс Хөшигийн хөндий эх үүсвэрт холбох цэвэр усны шугамын зурвасыг тогтоох, хамгаалалтад авах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан холбогдох байгууллагуудтай зөвшилцөн Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.

**4.2.1.** Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор дэд төвүүдийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, суурь дэд бүтцийг барьж байгуулах:

**Хэрэгжилт: "**Улаанбаатар хотын түгжрэлийн бууруулах талаар цогц арга хэмжээ авах тухай" саналуудыг бусад хэлтсүүдээс авч нэгтгэн танилцуулга бэлтгэсэн.

**4.2.3** Хөшигийн хөндийд шинэ хотууд болон эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх:

**Хэрэгжилт:** Орон сууц, олон нийтийн бүсийн, Эдийн засгийн чөлөөт бүсийн, Тээвэр, логистикийн, Оюутны хотхоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн үндсэн шийдэл, концепцийг гаргах шатандаа төлөвлөлтийн баримт бичиг боловсруулагдаж байна.

**Хэрэгжилт:** Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 143 дугаар тогтоолоор "Шинэ зуун мод" хотын хөгжлийн төлөвлөгөө батлагдсан. Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | “Орон сууц олон нийтийн бүс”-ийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг “Нэкст Степ Инженерин ХХК”,<br>“Сургалт- Эрдэм шинжилгээ - Үйлдвэрлэлийн цогцолбор”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг “Нарт дизайн” ХХК,<br>“Тээвэр логистик”-ийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг “Хот төлөвлөлт судалгааны институт” ОНӨҮГ тус тус боловсруулж байна.<br>Шинэ зуун мод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу боловсрогдсон цахилгаан, холбоо, ус хангамж, дулааны шугам сүлжээний барилга, байгууламж, үерийн уснаас хамгаалах үндсэн далан, сувгийн байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулагдсан.Төлөвлөлтийн системд бүртгэгдсэн.<br>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 143 дугаар тогтоолоор “Шинэ зуун мод” хотын хөгжлийн төлөвлөгөө батлагдсан.<br>Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу<br>“Орон сууц олон нийтийн бүс”-ийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг “Нэкст Степ Инженерин ХХК”,<br>“Сургалт- Эрдэм шинжилгээ - Үйлдвэрлэлийн цогцолбор”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг “Нарт дизайн” ХХК,<br>“Тээвэр логистик”-ийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг “Хот төлөвлөлт судалгааны институт” ОНӨҮГ тус тус боловсруулж ШУТХурлаар хэлэлцүүлж зураг төсөл нь магадлалын ерөнхий төлөвлөгөө дүгнэлт гаргах шатандаа явж байна.<br>**4.3.1.** Хангайн бүсийн тулгуур төв, Орхон аймгийн төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлсэн байна:<br>**Хэрэгжилт:** Хангайн бүсийн тулгуур төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврын төслийг боловсруулан холбогдох газруудтай зөвшилцөн, санал авч тусган Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Төслийн дагуу 2021/68 дугаар зургийн даалгавар 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Барилга хот байгуулалтын сайд баталсан. 2022 онд зургийн даалгаварт нэмэлт тодотгол хийж Барилга, хот байгуулалтын яамны ХБГХБХЗГ-т хүргүүлсэн.<br>Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар “Эн Эй Пи” ХХК-нд боловсруулсан Ханбогд сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг судлан танилцаж БХБЯ-ны ХБГХБХЗГ-т хүргүүлсэн. Ханбогд сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө Өмнөговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэгдэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан.<br>Цогтцэций сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж байгаа “Эрхэт” ХХК-тай 4 удаагийн уулзалтыг зохион байгуулж төлөвлөлтийн баримт бичиг 48 санал боловсруулан хүргүүлсэн.<br>- Өмнөговь аймгийн ИТХ-ын 2022 оны 09 дүгээр сарын 15-ний өдрийн 7/3 дугаар тогтоолоор “Эн Эй Пи” ХХК-ийн боловсруулсан Ханбогд сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө аймгийн ИТХ-аар хэлэлцэгдэн батлагдсан.<br>- Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө “Эрдэнэс таван толгой” ТӨХК-ийн санхүүжилтээр “Эрхэт констракшн” ХХК гүйцэтгэж байна. Цогтцэций сумын ИТХ, аймгийн ИТХ-аар тус тус хэлэлцэгдэн дэмжигдсэн. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Архитектур, хот байгуулалтын орон тооны бус зөвлөлөөр хэлэлцэгдсэн.<br>- Өмнөговь аймгийн Гурвантэс сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг нийслэлийн Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨҮГ боловсруулж байна.<br>Аймаг, сумын ИТХ, архитектур, хот байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэгдэхээр хүлээгдэж байгаа<br>- Хангайн бүсийн тулгуур төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгавар батлагдсан.<br>Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Барилга, хот байгуулалтын яамнаас зохион байгуулсан ч Төслийн гүйцэтгэгч шалгараагүйн улмаас Төсвийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д зааснаар төслийн хэмнэлтэд хамрагдан санхүүгийн эх үүсвэр татагдсан болно. | | |
| **Засгийн газрын тогтоол** | | | | |
| 1. | 2023.11.08-403<br>Их өгөгдлийн /big data/сан үүсгэх тухай | Тус ажлын хүрээнд зохион байгуулж буй “Төрийн байгууллагын мета өгөгдлийн цахим платформ” байгуулах арга хэмжээнд ГЗБГЗЗГ-аас 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр “Төрийн нэгдсэн мэдээллийн санд нэгдэх суурь нөхцөлийн бэлэн байдал” үнэлгээний асуулга болон “Мэдээллийн технологийн цогц удирдлагын үнэлгээ”-ний асуулга бөглөж үнэлгээнд хамрагдсан. Мөн Мета өгөгдлийн агуулгыг батлагдсан загварын дагуу nso.mn вэб сайтаар орж газар зүйн нэр, байр зүйн зураг, геодезийн цэг тэмдэгтийн мэдээллийг бүртгүүлсэн. | 100 | |
| 2. | 2023.10.11-377<br>Улсын хилийн зурваст газар ашиглуулах тухай | Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт орших хилийн Шивээхүрэн боомт орчимд 133.94 га газрыг ашиглуулах тухай Засгийн газрын тогтоол гарсан. Тогтоолын 2-т заасны дагуу тус газрыг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн. “Улсын хилийн зурвас газарт газар ашиглуулах тухай” гэрээний төслийг боловсруулж байна.<br>Тус ажлын хүрээнд зохион байгуулж буй “Төрийн байгууллагын мета өгөгдлийн цахим платформ” байгуулах арга хэмжээнд ГЗБГЗЗГ-аас 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр “Төрийн нэгдсэн мэдээллийн санд нэгдэх суурь нөхцөлийн бэлэн байдал” үнэлгээний асуулга болон “Мэдээллийн технологийн цогц удирдлагын үнэлгээ”-ний асуулгад бөглөж үнэлгээнд хамрагдсан. Мөн Мета өгөгдлийн агуулгыг батлагдсан загварын дагуу nso.mn вэб сайтаар орж газар зүйн нэр, байр зүйн зураг, геодезийн цэг тэмдэгтийн мэдээллийг бүртгүүлсэн. | 30 | |
| 3. | 2023.10.11-375<br>Улсын хилийн зурваст газар ашиглуулах тухай | Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт орших хилийн Гашуунсухайт боомт орчимд 16 га газрыг ашиглуулах тухай Засгийн газрын тогтоол гарсан. Тогтоолын 2-т заасны дагуу тус газрыг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн. “Улсын хилийн зурвас газарт газар ашиглуулах тухай” гэрээний төслийг боловсруулж байна. | 30 | |
| 4. | 2023.10.11-376<br>Улсын хилийн зурваст газар ашиглуулах тухай | Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг дэвсгэрт орших хилийн Ханги боомт орчимд 33.5 газрыг ашиглуулах тухай Засгийн газрын тогтоол гарсан. Тогтоолын 2-т заасны дагуу тус газрыг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн. “Улсын хилийн зурвас газарт газар ашиглуулах тухай” гэрээний төслийг боловсруулж байна. | 30 | |
| 5. | 2023.08.17-187<br>Барилга, Хот байгуулалтын Улсын албаны дэргэд гамшгаас | Засгийн газрын 2023 оны 08 дгаар сарын 17-ны өдрийн 187 дугаар тогтоолын дагуу байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийн, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн гишүүдийн гүйцэтгэх чиг үүрэг, Гамшгаас хамгаалах мэргэжлийн | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хамгаалах Мэргэжлийн анги байгуулах тухай | ангийн орон тооны бус бүлгийн тусгай үүрэг гүйцэтгэх бүлгүүдийн томилгоот бүрэлдэхүүн, Бусад төрлийн аюулт үзэгдэл, гамшиг, ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Гамшиг, ослын үед штабыг хээрийн нөхцөлд болон сургуулийн нөхцөлд нүүлгэн шилжүүлж, зохион байгуулах зураглал зэргийг шинэчлэн батлуулсан. | | |
| 6. | 2023.07.05-265 Газрын улсын хэрэгцээнд авах тухай | Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 265 дугаар тогтоолоор Дорнод аймгийн Матад сумын нутаг дэвсгэрт орших газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт “Матад-XX” талбайн 21392 га /213.92 км.кв/ газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан. Тогтоолын 2-т заасны дагуу улсын тусгай хэрэгцээний газартай давхцалтай иргэдийн нөхөх олговрыг шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсгийг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын тушаалаар байгуулж, иргэдтэй тохиролцож, гэрээ байгуулсан. Тогтоолын 3-т заасны дагуу тус газрыг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн. “Улсын тусгай хэрэгцээний газрыг ашиглах тухай” гурвалсан гэрээний төсөлд УУХҮЯ, Дорнод аймгийн ЗДТГ-аас санал авсан. | 70 | |
| 7. | 2023.06.14-231 Төлөвлөгөө батлах тухай | Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж агентлагийн даргаар батлуулан 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 1/2726 дугаартай албан бичгээр Хүний эрхийг хангах үндэсний хорооны ажлын албанд хүргүүлсэн. | 100 | |
| 8. | 2023.04.05-120 Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого” болон Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөр хэрэгжих инженерийн дэд бүтцийн буюу ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамж, цахилгаан хангамж харилцаа холбооны 5 давхарга, инженерийн бэлтгэл арга хэмжээний зам талбайн ус зайлуулах шугам сүлжээ, үерийн хамгаалалтын далан, сувгийн 2 давхарга, нийт 7 давхаргын зураг төсөл, төлөвлөлтийн давхаргын мэдээллийг бүртгэх хөгжүүлэлт гүйцэтгэх “Смарт дата” ХХК-тай 2023 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн №2023/170 дугаар бүхий зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулагдсан. Инженерийн дэд бүтэц, инженерийн бэлтгэл арга хэмжээний ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамж, цахилгаан хангамж, харилцаа холбоо, зам тээвэр, инженерийн бэлтгэл ажлын нийт 7 давхаргад мэдээлэл бүрдүүлэх маягтыг боловсруулж бусад системд мэдээлэл дамжуулах шийдлийг тодорхойлсон. Улсын Их хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдан, хэрэгжиж байгаа цахилгаан хангамжийн 1 төсөл арга хэмжээ Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.08 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын трассы. мэдээллийг бүрдүүлсэн. “Нийслэлийн замын хөгжлийн газар”-аас Улсын төсвийн хөрөнгөөр 2022-2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төслийн хүрээнд ашиглалтад орсон АН-4 Цагааннуур – Улаанбайшинт чиглэлийн 25.8 км, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 66.7 км, Чингис-Дадал чиглэлийн 50 км, Хүйтний хөндий- Арвайхээр чиглэлийн 60 км замуудын орон зайн болон орон зайн бус мэдээллийг бүрдүүлсэн ба /urban.gov.mn/-н хөгжүүлэлт дууссаны дараа системд бүртгэхээр бэлэн болгоод байна. | 100 | |
| 9. | 2023.02.08-55 Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай | Тус газарт 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ батлагдаагүй тул төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын тухайн онд батлагдсан дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийгдээгүй болно. | Н.Уранчимэг | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 10. | 2023.06.21-243<br>Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай<br>/нэг удаагийн буцалтгүй тусламж олгох/ | Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журамд орсон нэмэлт өөрчлөлттэй холбоотой 2024 оны төсөвт өөрчлөлт орохгүй бөгөөд 2024 онд 11 албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 2024 оны төсвийн төсөөлөлд тусган БХБЯ болон СЯ-нд хүргүүлсэн. | 100 | |
| 11. | 2023-242<br>Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай<br>/төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласан нэмэгдэл олгох журмын 3 дахь заалт/ | 2023 оны төсөвт 21 аймгийн ГХБХБГ болон Нийслэл агентлагийн цалин хөлс нэмэгдэл урамшуулал, НДШ-ийн зардал, Газрын нэгдмэл сангийн удирдлагын системийн үйл ажиллагааг ханган ажиллах үйл ажиллагааны зардал болон захиалагчийн техник хяналтын зардлыг төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх зохицуулалтуудыг тус тус хийж батлуулсан. Нэмэлт өөрчлөлтийг 2024 оноос хэрэгжүүлэхээр заасан тул бэлтгэл ажлыг хангаж 2024 оны төсвийн төсөөлөлд тусган БХБЯ болон СЯ хүргүүлсэн. | 100 | |
| 12. | 2023.07.19-278<br>Журам шинэчлэн батлах тухай<br>/Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах / | ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу 2023 онд бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдах 11 төрлийн 903.2 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээг Газрын даргын 2023 оны А/30 тушаалаар батлуулан худалдан авах ажиллагааг холбогдох мэргэжлийн хэлтсүүдтэй хамтран зохион байгуулан ажилласан.<br>2024 оны төсвийн хүрээний мэдэгдлийн саналыг боловсруулан БХБЯ-д 2023 оны 06 сарын 16-ны өдрийн 1/459 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Тус газрын 2024 онд улсын төсвийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсвийн саналыг дараах байдлаар боловсруулсан. Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол, Сангийн Сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан журам аргачлал, Сангийн Сайдын 2022 оны 03 сарын 24-ны өдрийн 9/1582 албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийг удирдлага болгон 2024 онд нийт 6 төсөл арга хэмжээг төлөвлөн Сангийн яамны хөрөнгө оруулалтын цахим систем болох (publicinvestment.gov.mn)-д программд төсөл арга хэмжээг шивж оруулсан. Мөн 2023 оны 05 сарын 09-ны өдрийн 1/920 тоот албан бичгээр БХБСайд /ТЕЗ/-д хүргүүлсэн.<br>2024 оны төсвийн төсөл 2024-2025 оны төсвийн төсөөлөлд төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 3,049.0 сая төгрөгөөр, төсвийн урсгал зардлыг 50,469.4 сая төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 17 төсөл арга хэмжээний 53,019.8 сая төгрөг, Төв аймгийн Сэргэлэн Алтанбулаг сумын газар чөлөөлөлтөнд 6,543.0 сая төгрөгийн нөхөн олговорын зардлыг олгохоор төсвийн төслийг боловсруулан БХБСайд ТЕЗ-даа 2023 оны 07 сарын 25 өдрийн 3/1563 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан.<br>Төсвийн тухай хуулийн дагуу Барилга, хот байгуулалтын сайдын төсвийн багцад тусгагдсан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг сангийн яамны холбогдох мэргэжилтэнээр хянуулан Ерөнхий сайдын төсвийн багцад шилжүүлсэн. | 100 | |
| 13. | 2023.06.21-240<br>Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай | ГЗБГЗЗГ-ын дарга, Нийслэлийн Засаг даргын хамтарсан Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2022 оны А/219, А/1602 дугаар тушаал, захирамжаар Нийслэлийн газар зохион байгуулалтын албыг 11 хэлтэс, 9+2 дүүргийн ГЗБА-ны бүтцийг тогтоож, газрын даргын 2023 оны Б/49 дүгээр тушаалаар зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал, зэрэглэлийг шинэчлэн баталсан. | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 21 аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн саналыг нэгтгэн мөн хүн амын тоо, нэгж талбарын тоог аймаг, сумаар гарган танилцуулга, судалгааг хийсний үндсэн дээр аймгийн Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанаар танилцуулан, аймгийн ГХБХБГ-ын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах, батлуулах ажлыг зохион байгуулж 2023 оны Б/10 дугаар тушаалаар батлан хүргүүлсэн. | | |
| 14. | 2023.06.21-241<br>Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай | 2023 оны төсвийн тодотголоор төрийн албан хаагч нарын цалингийн зардлыг Засгийн газрын 2023 оны 06 сарын 20-ны өдрийн 241 дүгээр тогтоол, орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагч нарын орон нутгийн нэмэгдлийг баталсаны дагуу цалингийн зардлын хуваарилалтыг хийж БХБСайд ТЕЗ-аараа дамжуулан Сангийн яамаар батлуулсан. Шинэчлэгдсэн цалингийн хэмжээгээр албан хаагчдын цалин хөлсийг олгон ажиллаж байна. | 100 | |
| 15. | 2023.05.31-213<br>Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай | Тус газрын Орон зайн, мэдээлэл технологийн хэлтсийн 4 албан хаагчийг мэдээлэл технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтны цалингийн хэмжээг итгэлцүүрийн дагуу цалин хөлсийг тогтоож цалинжуулан ажиллаж байна. | 100 | |
| 16. | 2023.08.16-294<br>Нийслэл Улаанбаатар хотод гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийн арилгах, нийслэлийн хот төлөвлөлт, газар зохион байгуулалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай | Газрын багц хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг эцэслэн боловсруулах үүрэг бүхий 5 ажлын хэсгийг газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/159 дүгээр тушаалаар байгуулсан. Газрын багц хуулийн төслийг УИХ-ын 2023 оны намрын ээлжит чуулган өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх даалгаврын хүрээнд Газрын багц хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг эцэслэн боловсруулж, засгийн газарт өргөн барих үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулж өгөх талаар Барилга, хот байгуулалтын сайдад 2023 оын 09 дүгээр сарын 21-ний өдөр 1/1956 тоот албан бичгийг хүргүүлсэн. Газрын багц хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл бэлэн болсон.<br>Агентлагийн чиг үүрэг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжих болсонтой холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл, танилцуулга, дагаж өөрчлөгдөх Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газрын тогтоолын төслүүдийг тус тус боловсруулж, Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.<br>Аймаг, сум, чөлөөт бүсийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй, тусгагдсанаас өөр зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг аймаг, сумын Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч нарт үүрэг болгосоны дагуу орон нутагт шинээр газар олгох ажлыг нээсэн бөгөөд газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хүрээнд газар олгох, төлөвлөгөөгүй аймгууд | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | яаралтай төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулах талаар аймгийн ГХБХБГ-ын дарга нартай цахим хурал зохион байгуулж чиглэл өгсөн. | | |
| 17. | 2023.04.19-145 Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай | Тогтоолын 2 дахь заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоолоор батлагдсан "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хил заагийг тогтоох ашиглах журам- ын 3.13.2-т заасны дагуу "Тусгай хэрэгцээний газрыг ашиглах" гурвалсан гэрээний төслийг боловсруулж байна. | 30 | |
| 18. | 2023.03.22-105 Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн Монгол Улсын иргэнд 2023 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг хавсралт ёсоор баталсан. | Монгол улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 105 дугаар тогтоолоор "Монгол улсын иргэнд 2023 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалт"-ыг баталсан. Ингэснээр улсын хэмжээнд нийт 29563 иргэнд 3583.07 га газрыг өмчлүүлнэ. Үүнээс 29549 иргэнд 3581.49 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй, 14 иргэнд 1.59 га газрыг аж ахуйн зориулалтаар үнээр нь тус тус өмчлүүлэхээр батлагдсан. Харин нийслэлийн хэмжээнд нийт 4386 иргэний эзэмшиж байгаа газрыг олгогдсон 255.23 га газрыг өмчлүүлэхээр батлагдсан.<br>Монгол Улсын Засгийн газрын тогтоолыг Газрын даргын 2023 оны 04 сарын 05-ны өдрийн 1/606-1/612 тоот албан бичгүүдээр нийслэлийн Газар зохион байгуулалтын алба болон 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлж, тогтоолыг хэрэгжүүлж ажиллах, тогтоолд тусгагдаагүй байршилд газар өмчлүүлэхгүй байх талаар чиглэл хүргүүлсэн. | 100 | |
| 19. | 2023.03.15-100 "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын хүн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний жагсаалт"-ыг 2 дугаар хавсралт, "Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан мэдээлэл хариуцагчаас олгох лавлагаа, тодорхойлолтын загвар"-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсан. | Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журмын дагуу тус газраас үзүүлж буй үйлчилгээг батлагдсан лавлагаа, тодорхойлолтыг загварын дагуу гаргаж иргэд, хуулийн этгээдэд үйлчилж байна. | 100 | |
| 20. | 2023.02.08-49 Монгол Улсын хөгжлийг боомилон сааруулагч гол хүчин зүйлс болох авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын олон талт | Авлигатай тэмцэх таван үйл ажиллгааг зарласан. Авлигатай тэмцэх шүүр ажиллагааны хүрээнд Монгол Улсын Сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалангаас 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн ХЭГ/595 тоот "Чиглэл хүргүүлэх тухай" албан бичгийн хүрээнд Газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/43 дугаар тушаалаар "Ажлын хэсэг"-ийг байгуулсан.<br>Аймгийн ГХБХБГ-т Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн чиглэлийн хүрээнд тус газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 1/512 тоот албан бичгээр чиглэл хүргүүлж, цахим хурал зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | арга хэмжээг авч хэрэгжүүлж, авлига, хууль бус үйлдэлтэй үл эвлэрэх, үл тэвчих хандлагыг олон нийтийн дэмжлэг, оролцоотойгоор төлөвшүүлэн бүх шатанд авлигыг таслан зогсоосны үндсэн дээр хүний эрхийг хананган нийтийн эрх ашгийг хамгаалж, хувийн хэвшлийг дэмжин хөгжүүлж эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласан. | хангаж ажилласан. Ажлын хэсгийн багийн бүрэлдэхүүн Төрийн албаны тухай хуульд заасан төрийн жинхэнэ албан хаагчид тавигдах нийтлэг болон тусгай шаардлага хангаагүй, албан тушаалын тодорхойлолтод заасан, мэргэжил, мэргэшил, ур чадварын шаардлагыг хангаагүй, дүйцүүлэн томилох журам зөрчсөн, төрийн жинхэнэ албан тушаалд ерөнхий болон тусгай шалгалт өгөөгүй, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчиж томилогдсон эсэхийг тус газрын нийт 77 албан хаагч үүнээс төрийн захиргааны 64, төрийн үйлчилгээний 13 албан хаагчийн хувийн хэрэгт нэг бүрчлэн үзлэг, шалгалтыг хийж, баримт бичгийг нягталж үзэж ажилласан.<br>Мөн байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг шинээр боловсруулж, газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/25 тоот тушаалаар батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | | |
| 21. | 2023.01.04-06<br>"Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Хяналтын улсын байцаагчийн үнэмлэхийн загвар"-ыг 2 дугаар хавсралт, "Хяналтын улсын байцаагчийн тэмдгийн загвар"-ыг 3 дугаар хавсралт, "Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг олгох, хэрэглэх, түүнд хяналт тавих журам"-ыг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсан. | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 6 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам", 4 дүгээр хавсралтаар баталсан "Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг олгох, хэрэглэх, түүнд хяналт тавих журам"-ыг үндэслэн Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 17 дугаар тушаалын 1 дүээр хавсралтаар хяналтын улсын байцаагчдад салбарын хяналтын чиглэлийн дугаар олгосон, 2 дугаар хавсралтаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын газар, геодези, зураг зүйн хяналтын улсын /ахлах/ байцаагчдад улсын байцаагчийн эрхийг албаны болон хувийн дугаарын хамт олгосон. Мөн аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын улсын байцаагч болон ахлах байцаагч нарт сургалт зохион байгуулж, байцаагчийн эрх, үнэмлэхийг гардуулах ажлыг зохион байгуулсан. | 100 | |
| 22. | 2022-491<br>"Журам батлах тухай" Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-д нэмэлт өөрчлөлт оруулсан. | Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас 1-25 хувиар бодож олгохоор тогтоосоны дагуу нийт албан хаагчдын 2023 оны цалингийн санг шинэчлэн батлаж хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100 | |
| 23. | 2022.12.28-488<br>Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, | Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу байгууллагын албан хаагчдын цалингийн шатлалыг 2023 оны 01 | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай | сарын 01 өдрөөс 2023 оны 06-р сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд даган мөрдөж ажилласан. | | |
| 24. | 2022_490 Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-д нэмэлт өөрчлөлт оруулсан. | Тайлант хугацаанд нийтээр амрах баярын өдөр ажилласан албан хаагчдыг нөхөн амруулахыг нэгжийн дарга нарт газрын даргын тушаалд дурдан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 | |
| 25. | 2022.12.28-487 Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсан. | Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтыг Газрын даргын 2023 оны Б/10, Б/49 тоот тушаалаар тус тус шинэчлэн баталсан. | 90 | |
| 26. | 2022-481 Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын дүнгийн мөрөөр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, холбогдох албан тушаалтанд даалгасан. | Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулах, цахим бүртгэлд бүрэн хамруулах, газрыг үнэлж, санхүүгийн тайланд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт даалгасан. Дээрх ажлын хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга нар 2022 онд хамтран ажиллах 2022/47 тоот "Мэдээлэл солилцох гэрээ"-г байгуулан төрийн мэдээллийн ХУР цахим системээр дамжуулан Газрын кадастрын мэдээллийн сангийн мэдээллийг солилцон ажиллаж байна.<br>Газрын кадастрын мэдээллийн санд Улсын хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн нийт 19325 нэгж талбар буюу 80117.6 га талбай бүхий газар бүртгэлтэй байгаа бөгөөд дээрх газруудыг Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын дагуу газрын үнэлгээг тооцоход нийт 6.1 их наядын үнэлгээтэй байна.<br>Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын удирдлагууд 2023 оны 03 дугаар сард уулзалт зохион байгуулж бүртгэлтэй мэдээлэл болон тус газрын мэдээллийг нэгтгэх, цахим системд бүртгэгдээгүй төрийн болон орон нутгийн өмчийн газар, үл хөдлөх хөрөнгийг бүртгэх ажлыг зохион байгуулан үүрэг бүхий хамтарсан ажлын хэсэг байгуулахаар тохиролцсон. | 70 | |
| 27. | 2022.12.28-479 "Хяналт шалгалт хийх нийтлэг журам" болон "Хяналт шалгалтын баримт бичгийн загвар"-ыг тус тус шинэчлэн баталсан. | Хяналт шалгалтын нийтлэг журмын дагуу Барилга, хот байгуулалтын яамны Салбарын хяналтын газрын улсын ерөнхий байцаагчийн баталсан 02-00/06 дугаар удирдамжаар улс болон нийслэлийн хөрөнгө оруулалтын төсвөөр шинээр баригдаж байгаа Хан-Уул дүүргийн 21, Баянзүрх дүүргийн 7, Баянгол дүүргийн 10, Сонгинохайрхан дүүргийн 10, Чингэлтэй дүүргийн 3, Сүхбаатар дүүргийн 4, Багануур дүүргийн 2, мөн 02-00/07 дугаартай удирдамжаар ашиглагдаж байгаа барилга, байгууламжийн газар эзэмшил, ашиглалтын байдалд одоогоор /Хан-Уул дүүргийн 49, Баянзүрх дүүргийн 60, Баянгол дүүргийн 120, Сонгинохайрхан дүүргийн 325, | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Чингэлтэй дүүргийн 48, Сүхбаатар дүүргийн 21 урьдчилсан сэргийлэх хяналт шалгалт тус тус хийгдэж байна. /хугацаа болоогүй/ Монгол Улсын Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн 4, Засгийн газрын 11-11 утсаар ирүүлсэн 3, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгавар 3, өргөдөл гомдол 11, албан бичиг 35 хүлээн авч "Хяналт шалгалт хийх нийтлэг журам"-ын дагуу 13 удирдамж батлуулан хяналт шалгалт хийж нийтийн эзэмшлийн зам талбай, явган хүний зам хаасан, зөвшөөрөлгүй өргөтгөл барьсан 5 иргэн, аж ахуйн нэгжид зөрчлийг арилгуулах улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлэн 4 зөрчлийг арилгуусан, албан шаардлагын биелэлтийг хангаж ажиллаагүй 1 аж ахуйн нэгжид 500,0 мянган төгрөг, мөн хяналт шалгалттай холбоотой 2 иргэн, 3 аж ахуйн нэгжид зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж хялбаршуулсан журмаар 10560.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч барагдуулсан байна. Барилга, хот байгуулалтын яамны салбарын хяналтын газраас ирүүлсэн "Журмын хэрэгжилтийг хангуулах тухай" 2023.02.03-ны өдрийн 11/412 дугаартай албан бичгийн дагуу "Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлийг байгуулахад тавих шаардлага" MNS5140-2:2021 стандартын дагуу хяналт хэрэгжүүлэх төрийн байгууллагын нэр дээр Мандах урлан ХХК-аар улсын байцаагчдад шаардлагатай 12 нэр төрлийн 2300 хэвлэмэл хуудас хэвлүүлсэн. | | |
| 28. | 2022-470 "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам"-ыг шинэчлэн баталсан. | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журмыг Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулах, тэдгээрийн төсөлд санал өгөхөд баримтлан ажиллаж байна. | 100 | |
| 29. | 2022-447 Улсын хилийн зурвас газарт газар ашиглуулах тухай | Дорнод аймгийн Чойбалсан сумын нутаг дэвсгэрт хавсралтад заасан байршил, хилийн заагийн солбицол, талбайн хэмжээ бүхийн улсын хилийн зурвас газарт гаалийн хяналтын бүс, чингэлэгт тээврийн терминал барих зориулалтаар 28 га, гаалийн баталгаат агуулах барих зориулалтаар 15 га газрыг тус тус ашиглах газрын мэдээллийг газрын кадастрын улсын мэдээллийн санд зохих журмын дагуу бүртгэж, газар ашиглах гэрээг Хилийн боомтын захиргаатай байгуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ГЗБГЗЗГ-т даалгасан. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Хил хамгаалах ерөнхий газар, Хилийн боомтын захиргааны дарга нар 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөр 85/36/08 дугаартай гурвалсан гэрээг байгуулсан. Засгийн газрын 2022 оны 447 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан 2 газрын хил заагийг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж, кадастрын зургийг Боомтын захиргаанд гаргаж өгсөн. | 100 | |
| 30. | 2022_377 Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламжийн зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай | 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай" 377 дугаар тогтоолоор Газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан. Засгийн газрын 2017 оны 287 дугаат тогтоолоор батлагдсан журмын дагуу 3 талт гэрээний төслийг боловсруулан Төв аймгийн Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд санал авахаар хүргүүлэн ажиллаж байна. Саналыг ирүүлмэгц журмын дагуу гэрээ байгуулж, гэрчилгээ олгох ажиллагааг зохион байгуулна. | 90 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 31. | 2022_349<br>Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах тухай | Энэ ажлын хүрээнд БОАЖЯ-ны төлөөлөл, Газар зохион байгуулалтын хэлтэс, Смарт эко транс ХХК-тай уулзалт хийсэн. БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын удирдамжаар Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах газрын байршлыг тогтоох ажлыг 2022 оны 3 дугаар сарын 25-26-ны өдөр хийсэн.<br>Засгийн газрын 2022 оны 95 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, газрын байршил, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицол, талбайн хэмжээг тогтоосон мэдээллийг ГЗБГЗЗГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 1/594 тоот албан бичгээр Барилга, хот байгуулалтын Сайдад хүргүүлсэн.<br>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 95 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн хилийн Гашуунсухайт боомтод олгосон 66 га газар нь Улсын Их Хурлын 1996 оны 43 дугаар тогтоолоор улсын тусгай хамгаалалтад авсан Говийн бага /Б/ Дархан цаазат газрын хил заагт хамаарч байгаа бөгөөд БОАЖЯ-ны эрхлэх асуудал тул тогтоолын хэрэгжилтийг хэрхэн хангаж, хамтарч ажиллах талаар санал авах албан бичгийг хүргүүлээд байна. | 90 | Улсын Их Хурлын 1996 оны 43 дугаар тогтоолоор улсын тусгай хамгаалалтад авсан Говийн бага /Б/ Дархан цаазат газрын хил заагт хамаарч байгаа газартай давхцалтай |
| 32. | 2022_356<br>Бага хурал зохион байгуулах тухай | НҮБ-ын цөлжилттэй тэмцэх суурь конфенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулахтай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран ажиллаж байгаа бөгөөд Тус газраас бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг 2022 онд бэлчээрийн газрын мониторингийн 5166 цэгт хийсэн ба Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс бэлчээрийн мониторингийн 1513 цэгийг мэдээг авч нэгтгэн нийт 6679 цэгт дүн шинжилгээ хийж, бэлчээрийн газрын төлөв байдлын зургийг боловсруулж нөхөн сэргээх талбайг тодорхойлсон. Гарсан үр дүнг санал, дүгнэлтийн хамт Нийслэлийн газар зохион байгуулалтын алба болон 21 аймгийн ГХБХБГазарт болон БОАЖЯаманд 1/2132, ХХААХҮЯаманд 1/2121 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | 100 | |
| 33. | 2022_350<br>Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 350 дугаар тогтоолоор Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.<br>Энэхүү тогтоолын 7 дугаар заалтаар "Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай" Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 27 дугаар тогтоол, "Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2018 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 289 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсон тул “Газрын шинэтгэлийн үндэсний хороо” татан буугдсан болно.<br>Газрын шинэтгэлийн үндэсний хороо татан буугдсантай холбогдуулан 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр тус Үндэсний хорооноос 2022 онд гаргасан шийдвэрийн | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хэрэгжилт, 2022 оны үйл ажиллагааны тайланг гарган, 2018-2022 оны хуралдааны баримт бичгүүдийг 311 хуудас бүхий 8 хадгаламжийн нэгж үүсгэн архивласан болно. | | |
| 34. | Хэлэлцээрийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 2022_280 3. Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсэд хилийн хяналтын цэг байгуулах арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт, "Замын-Үүд чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г Хамтын ажиллагааны бүсийн Хятадын талын төлөвлөгөөтэй уялдуулах арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт тус тус үүрэг болгосугай. | "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-д Замын-Үүд, Алтанбулаг, Гашуунсухайтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийн бүрдэлийг оруулсан.<br>Гаалийн ерөнхий газрын Боомтын хөгжлийн газарт 1/1675 дугаар албан бичиг хүргүүлэн 2011-2021 оны хооронд боловсрогдсон Монгол Улсын шалган нэвтрүүлэх "Замын-Үүд", "Алтанбулаг", "Гашуунсухайт", "Шивээхүрэн", "Бичигт" боомтуудын ерөнхий төлөвлөгөөг тоон байдлаар авч Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулж, "Боршоо", "Ханх", "Ханги", "Булган", "Бургастай", "Зэлтэр" боомтуудын ерөнхий төлөвлөгөөний баримт бичгүүдийн ерөнхий төлөвлөгөөний зураглалын материалын төлөвлөлтийн хэсэг болон тайлбар бичгийн цаасан материалыг PDF өргөтгөлөөр хуулбарлаж авсан бөгөөд мэдээллийг "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-д оруулан боомтуудыг хөгжүүлэх, газрын асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий "Ажлын хэсэг"-ийг мэдээ мэдээллээр хангаж ажиллахаар төлөвлөсөн.<br>Монгол Хятадын Замын-Үүд, Эрээний Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд хамтарсан гүйцэтгэлийн ажлын хэсгээс нэгдсэн төлөвлөлтийн концепцийн эхний саналыг боловсруулан танилцуулга бэлтгэгдсэн. Төслийн саналд хилийн гол орцоос гадна ачаа тээвэр логистикийн, хилийн аялал жуулчлалын нийт 3 орцтой байхаар санал гарсан.<br>Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Замын-Үүд чөлөөт бүсийн шалган нэвтрүүлэх цогцолбор, эхний ээлжийн барилгажих хэсгийн 2 дугаар хэлхээний инженерийн шугам сүлжээ, Чөлөөт бүсийг сумын төвтэй холбох болон БНХАУ-ын Эрээн чөлөөт бүстэй холбох авто зам, хог хаягдлыг цуглуулан ангилах төвийн ажлын зураг төслийн гүйцэтгэгчээр "Сонголт дизайн"ХХК шалгаран ажлаа эхлүүлээд байна. | 90 | |
| 35. | 2022 оны №267 Геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоог шинэчлэн батлах тухай | Тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор УБ хотын том масштабтай газрын зураг зохиох ажлын төсвийн тооцоог гаргаж нийслэлийн төсвөөр 2023 онд хийлгэж өгөх асуудлыг ЗД-д уламжлуулахаар 1/1489 албан тоотыг 2022.08.04-ний өдөр Барилга, хот байгуулалтын Сайдад хүргүүлэв.<br>ЗГ-ын 2021 оны 161-р тогтоолд судалгаа хийж "Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, хөтөлбөрийн дагуу 68 сумын төвд геодезийн сүлжээг шинэчлэх, 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох төсвийн тооцоо хийж 2023 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгав.<br>Дээрх 2 ажлыг 2023 онд хийхээр, бусад сум, сууринд хийх ажлыг 2024-2025 онд хийхээр төлөвлөгөө боловсруулан 2022.08.10-ны өдрийн 1\1533 тоотоор Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлэв.<br>Төлөвлөгөөг 2022.08.30-ны өдөр Барилга, хот байгуулалтын Сайдаар батлуулав.<br>Дархан-Уул аймгийн төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох төсвийн тооцоо хийж орон нутгийн төсвөөр зургийг хийлгүүлэх тухай албан тоотыг Дархан-Уул аймгийн ЗД-д уламжлуулахаар 2022.08.23-ны өдрийн 1/1625 тоотыг Барилга, хот байгуулалтын Сайдад хүргүүлэв. | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Орхон аймгийн төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох төсвийн тооцоо хийж орон нутгийн төсвөөр зургийг хийлгүүлэх тухай албан тоотыг Орхон аймгийн Засаг даргад уламжлуулахаар 2022.08.23-ны өдрийн 1/1627 тоотыг Барилга, хот байгуулалтын Сайдад хүргүүлэв.<br>19 аймгийн төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох төсвийн тооцоо хийж орон нутгийн төсвөөр зургийг хийлгүүлэх тухай албан тоотыг 19 аймгийн ЗД-д уламжлуулахаар 2022.09.14-ний өдрийн 1/1789 тоотыг Барилга, хот байгуулалтын Сайдад хүргүүлэв.<br>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, баталсан. Төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана. | | |
| 36. | 2022 оны №182<br>Атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх тухай | Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 182 дугаар тогтоолоор Төв аймгийн Баян, Баянжаргалан сумдад атар газраас тариалангийн газарт шилжүүлсэн 2500 га газрыг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж тариалангийн ангилалд оруулсан. | 100 | Бүрэн хэрэгжсэн тул хасуулах саналтай |
| 37. | 2022 оны №180<br>Хаягийн нэгдсэн сангийн нэгдсэн системийг орон зайн өгөгдөл, мэдээллийн геопорталаар дамжуулан хэрэглээнд нэвтрүүлэх | Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх шийдвэр гарсантай холбогдуулан Хаягжуулалтын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 325 дугаар журмыг шинэчлэх, Хаягийн мэдээллийн системийг ажиллуулах журмыг боловсруулж, батлуулах үйл ажиллагааг зохион байгуулсан. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран байгуулсан ажлын хэсгийн хүрээнд 05 дугаар сарын 17-ны өдөр уулзалт зохион байгуулж Улсын хэмжээнд хаягийн мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл мэдээллийг 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдөр хүргүүлсэн. Тус мэдээлэлд суурилан зэрэгцүүлсэн хаягийн сан байгуулсан. Мөн тогтоол батлагдсантай холбогдуулан Нийслэлийн хот төлөвлөлт хөгжлийн газар болон Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран 9 дүүргийн төрийн байгууллагуудын холбогдох мэргэжилтэнүүдэд хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийн хэрэглээ, ач холбогдолын талаар сургалт зохион байгуулсан. "Хаягийн мэдээллийн нэгдсэн систем байгуулах" арга хэмжээг хэрэгжүүлж улсын хэмжээнд нэгж талбар, барилгын хаяг, гудамжны нэр, дугаарыг зохих журмын дагуу шалган засварлан, нэгдсэн стандартад оруулж, хаягийн мэдээллийн санг үүсгэн 1:1000 болон 1:100 000 масштабтай байрзүйн зургийн мэдээллийг агуулсан, байрлалд суурилсан Хаягийн мэдээллийг нэгдсэн системийг байгуулах ажлын зохион байгуулсан. Тус системийг Засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоолоор хэрэглээнд нэвтрүүлэхээр шийдвэрлэж, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийн хаягийн мэдээллийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах хаягжуулах ажлыг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөвт тусгайн шийдвэрлүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан. Үүнтэй холбоотойгоор 21 аймгийн 221 сумaнд 2.21 тэрбум төгрөгөөр 130150 тэмдэгт байршуулаад байна.<br>Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газраас 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 05/4008 тоот албан бичгээр 9 дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн нийт 28970 барилга байгууламжийн хаягийн мэдээллийг ГКМСистемийн барилгын давхаргад | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | шинэчлэн хөрвүүлэх ажлыг 11 сарын 08 өдөр гүйцэтгэсэн. Хаягийн нэгдсэн системд давхардсан нэгж талбарыг цэгцлэх /устгах/, гудамжны орц гарыг дахин уншуулах, гудамжнаас хамааран нэгж талбарын орц гарыг баруун, зүүнээр тохируулах, хаяг уншуулах ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд Чингэлтэй, Сүхбаатар, Баянгол, Хан-Уул, Баянзүрх дүүргүүдийг уншуулж дуусаад байна.<br>Барилга, хот байгуулалтын сайд болон цахим хөгжил харилцаа холбооны сайдын 2022 оны 227/А76 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс гарсан шийдвэрийн дагуу Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газрын www.ebarilga.ub.gov.mn цахим системийн барилгын геометрийг Хаягийн мэдээллийн сантай сервесээр холбож, хаягийн мэдээллийн сангаас барилгад хаяг өгч, хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан / www.urban.gov.mn /-тай холболт хийсэн. Хаягийн мэдээллийн сангийн баазыг Геопортал цахим системтэй холболт хийж шинэ хаягийг геопорталаар дамжуулан хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болсон. | | |
| 38. | 2022 оны №171<br>Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай | Тус тогтоолоор Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах зориулалтаар олгогдсон нийт 1217.4 га газрыг Газрын кадастрын мэдээллийн сангийн Улсын тусгай хэрэгцээний давхаргад 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдөр бүртгэсэн.<br>"Улсын тусгай хэрэгцээний газрыг ашиглах" тухай гурвалсан гэрээний төсөлд 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас санал ирүүлсэн бөгөөд Орхон аймгийн ЗДТГ-аас гэрээний төсөлд саналыг авч, гэрээг баталгаажуулж, гэрчилгээг олгосон. | 100 | Бүрэн хэрэгжсэн тул хасуулах саналтай |
| 39. | 2022 оны №7<br>Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | Байгууллагын цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр чиг үүрэгтэй холбоотой мэдээ мэдээллийг Монгол хэлээр сурталчлах ажлыг тогтмол хийж гүйцэтгэв. Тогтоолын хэрэгжилтийг хангаН ажиллаж байна. 2022 оны 3 улирлын байдлаар 290 мэдээ, мэдээлэл бэтгэж, цахим хуудсанд оруулахдаа Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан.<br>Газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг 2022 онд хийж буй аж ахуйн нэгжүүд Газар зүйн нэр монгол хэл дээр батлагдсан эсэхийг хянаж, монгол хэлнээс өөр хэл дээр батлагдсан нэрийг УИХ-ын тогтоолоор хүчингүй болгохоор нэрийн жагсаалтыг гаргаж байна.<br>2021 оны газар зүйн нэрийн судалгаагаар монгол хэлнээс өөр хэл дээр батлагдсан 186 газар зүйн /Дархан-Уул аймагт 13, Сэлэнгэ аймагт 115, Хэнтий аймагт 58/ нэрийг хүчингүй болгуулахаар ажиллаж байна.<br>Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 7 дугаар тогтоолын 1.1 болон 4, 5.5 дахь заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор “Төрийн албан хаагчийн нэрийн хуудас”, "MNS 5283:2022, Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага" стандартын төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг СХЗГ-ын даргын 2022.04.08-ны өдрийн А/70 дугаар тушаалаар байгуулагдаж тус газраас 2 албан хаагч Ажлын хэсэгт ажиллалаа. СХЗГ-ын даргын 2022 оны 07 сарын 08-ны С/31 тоот тушаалаар “Төрийн албан хаагчийн нэрийн хуудас MNS 6978:2022” стандарт батлагдсан ба тус стандартад төрийн албан хаагчийн нэрийн хуудас нь кирилл болон үндэсний монгол бичгээр бичигдэхээр тусгагдсан. | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | СХЗГ-ын даргын 2022 оны 09 сарын 15-ны С/41 тоот тушаалаар батлагдсан "MNS 5283:2022, Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага" стандартад хаягийн самбар, хаягийн тэмдэг, хаягийн зурган самбар, байгууллагын нэрийн тэмдгийг кирилл болон монгол бичгээр бичиж, байшин доторх хаалганы тэмдэгт кирилл, монгол бичиг, брайл үсгээр бичигдэхээр болсон.<br>Засгийн газрын 2022 оны 05-р сарын 07-р тогтоолын дагуу Төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу Монгол бичгийн сургалтыг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагчдад зохион байгуулсан. Хэлний бодлогын зөвлөл, Архивын ерөнхий газрын хамтарсан Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III-ийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд боловсруулсан эрх зүйн шинэчилсэн стандартыг танилцуулах, 21 аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад мэдээлэл өгөх, үндэсний бичгээр цахим бичвэр боловсруулж турших хэвлэмэл хуудас ашиглах зөвлөгөө өгөх үүднээс зохион байгуулсан сургалтанд 2022 оны 10 дугаар сарын 28-нд хамруулсан. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 18-ны 96 дугаар тогтоолоор баталсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийг хэлэлцэн баталсан. Үүнтэй холбоотой албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн албан хэрэг хөтлөлтийг Монгол хэл, бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | | |
| 40. | 2021 оны 388 дугаар тогтоол Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай | Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2021 оны 388 дугаар тогтоолын 5 дугаар зүйлд Төсвийн хэмнэлтийн горимд ажиллах чиглэлийг баримтлан ажиллаж өр, авлага үүсгэхгүй байх арга хэмжээ авч, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосон байна. Тогтоолыг чанд мөрдөн, тогтоосон төсөвт зардлуудыг үргүй зарцуулахгүй байх, хэмнэх чиглэл барин ажиллаж байна. | 100 | |
| 41. | 2021 оны №374 Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолд заасан хугацаанд холбогдох байгууллагууд руу биелэлт, тайланг хүргүүлэн ажиллаж байна. | 100 | |
| 42. | 2021.10.13 №315 "Аж ахуйн нэгжийн тооллого явуулах тухай" | Засгийн газрын 2021 оны 315 дугаар тогтоолын дагуу ГЗБГЗЗГ-ын даргын 2021 оны А/215 тоот тушаалаар Ажлын хэсэг байгуулан төлөвлөгөө гарган ажилласан. Нийт 372 аж ахуйн нэгжийг 100 хувь аж ахуйн нэгжийн тооллогод хамруулсан. | 100 | Бүрэн хэрэгжсэн тул хасуулах саналтай |
| 43. | 2021.09.08 №280 Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай | "Туул-Сонгино усны нөөцийн цогцолбор" төслийг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт 5 байршилд нийт 43.6 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, газрын байршил, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицол, талбайн хэмжээн мэдээллийг Газрын кадастрын цахим системд бүртгэв. Мөн 3 талт гэрээний төслийг бэлтгэн Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.<br>Эдийн засаг, хөгжлийн яамнаас 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 03/630 дугаартай албан бичгээр төслийн концессын гэрээг цуцлах саналтай байгаа бөгөөд | 90 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | тус концессын гэрээний асуудлыг Эрчим хүчний яамтай санал солилцон шийдвэрлэсний дараа "Улсын тусгай хэрэгцээний газрыг ашиглах тухай" гурвалсан гэрээний төсөлд санал өгөх боломжтой гэж мэдэгдсэн тул гурвалсан гэрээ байгуулах ажил хойшлогдоод байна. | | |
| 44. | 2021.06.01 №160 “Журам батлах тухай” | Тус журмын дагуу 2023 оны Төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж төсвийн хязгаарт саналыг 2022 оны 2 дугаар улиралд багтаан Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Мөн 2023 оны Төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөллийг боловсруулан Барилга, хот байгуулалтын яам болон Сангийн яаманд хүргүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж, уг журмыг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгох, хяналт тавих, тайлагнахад үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. | 100 | |
| 45. | 2021.04.28 №109 “Журам батлах тухай” | “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хүрээнд Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх зорилгоор, байгууллагын цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр 7 хоног бүр тогтмол мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд зориулж байгууллагын олон нийтийн сүлжээ /нүүр ном/-нд иргэдэд хүргэн албан ёсны пейж хуудсанд 406 мэдээ, вэб хуудаст 134 мэдээ оруулав.<br>2022 оны 4 дүгээр улирлын байдлаар урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлтэй холбоотой 9 тушаал, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл 53, зардал гаргасан 49 тушаалыг шилэн дансанд байршуулсан. Байгууллагын батлагдсан орон тоонд ажиллаж буй албан хаагчдын мэдээллийн өөрчлөлтийг 11 удаа шинэчилэн оруулсан. | 100 | |
| 46. | 2021.05.05 №115 “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” | Газрын албан хаагчдыг PCR болон түргэвчилсэн шинжилгээнд тус бүр 2 удаа хамруулсан. Вакцины 1 дүгээр тунд 91 албан хаагчийг хамруулж, Вакцины 2 дугаар тунд 89 албан хаагчийг хамрагдаж, 3 дугаар тунд 16 албан хаагч хамрагдаад байна. 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 05 дугаар сарын 08-ны өдөр хүртэлх хугацаанд нийт албан хаагчдын 10%, 05 дугаар сарын 08-ны өдрөөс 06 дугаар сарын 02-ны өдөр хүртэл хугацаанд 30%-ийн ирцтэйгээр ажиллаж, үлдсэн 70% ийн ажилчид цахимаар ажилласан бөгөөд БХБЯамны Төрийн нарийн бичгийн даргаас ирүүлсэн чиглэлийн дагуу 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 8 дугаар сарын 31-ны хооронд албан хаагчдын 70 хүртэлх хувьд ээлжийн амралт олгож биеэр эдлүүлсэн. Байгууллагын албан хаагчдыг Вакцины 3 дугаар тунд идэвхитэй хамрагдахыг уриалж ажилласан бөгөөд 10-11-р сард 56 албан хаагч хамрагдаад байна. Ковид-19 цар тахалын байгууллагын цаг үеийн мэдээг 2021 онд Барилга, хот байгуулалтын яамны шуурхай штабт өдөр бүр мэдээллэн ажилласан. 2022 онд 1 сард Коронавируст халдвар /Ковид/-ын тархалтын түвшинд үндэслэн хүн хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журмыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж газрын даргаар батлуулсан. 2022 оны 02 дугаар сарын 14 өдрөөс эхлэн Засгийн газраас цар тахлын улбар шар түвшинг шар түвшинд шилжүүлж, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг цуцалсан. | 100 | Хэрэгжиж дууссан заалт тул хяналтаас хасуулах саналтай |
| 47. | 2021.03.24 №76 “Ажлын хэсэг байгуулах тухай” | Нийслэлийн Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэг, Төв аймгийн Алтанбулаг, Сэргэлэн, Баян сумын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх Рашаант-Мааньт чиглэлийн Богдхан | 90 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | төмөр замын зурвас газарт иргэн, хуулийн этгээдийн эзэмшил, өмчлөл, ашиглалтад олгосон нийт 798,8 га талбай бүхий 749 нэгж талбарын нөлөөлөлд өртөж байгаа бөгөөд 71 тэр бум төгрөгний нөхөн олговор олгох урьдчилсан тооцоо, судалгааг гаргаж ажлын хэсэгт танилцуулсан.<br>Төсөл хэрэгжүүлэгчээс төмөр замын трассын ажлын зургийг баталгаажуулж ирүүлээгүйгээс тусгай хэрэгцээнд авах газрын хэмжээ, байршил тодорхойгүй байна. Трассыг яаралтай баталгаажуулж ирүүлэх тухай тус газрын 1/1370 тоот албан бичгийг төсөл хэрэгжүүлэгчид 2022 оны 07 сарын 06-ны өдөр хүргүүлсэн. ЗТХЯ-наас 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 3/4323 дугаартай албан бичгээр Богдхан төмөр замын чигийн дагуух зурвас газрыг улсын тусгай хэрэгцээнд авах солбицол тодорхой болж саналаа ирүүлсэн бөгөөд журмын дагуу бэлтгэл ажлыг хангаж журмын 3.9.7-д заасны дагуу НИТХ, Төв аймгийн ИТХ-ын саналыг авахаар 2022 оны 1/1886 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Одоогийн байдлаар харьяалах орон нутгийн ИТХ-ын санал ирээгүй байна. | | |
| 48. | 2021.03.10 №58<br>“Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл батлах тухай” | Тогтоолыг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлэн ажиллав. Сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлд хүргүүлэн Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажиллаж байна. | 100 | |
| 49. | 2021.02.21 №45<br>“Журам батлах тухай” | Түр журамд заасны дагуу халдварын судалгаа, өвчний мэдээлэл, эрсдэлийн үнэлгээ, тандалтын тоон мэдээнд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн халдварын тархалтын түвшинг тодорхойлж, Барилга, хот байгуулалтын яаманд тухай бүр хүргүүлэн ажилласан. | 100 | |
| 50. | 2020.09.02 №92<br>“Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын чигийг батлах тухай” | Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор Төмөр замын шугамын чиг тогтоосон. Тогтоолд заасны дагуу батлагдсан чигийн дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай болон давхацсан газрыг чөлөөлөх, шинээр газар олгохгүй байх асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх зорилгоор Газрын кадастрын мэдээллийн санд төмөр замын чиг шугамыг бүртгэж, шинээр газар олгох асуудлыг тухайн зурвас газарт зогсоосон байгаа болно. | 100 | |
| 51. | 2020.04.29 №152<br>“Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 02 өдрийн 152-р тогтоолоор батлагдсан журмын өөрчлөлтийн хүрээнд газрын дуудлага худалдааг зохион байгуулан ажиллаж байна. Улсын хэмжээнд газрын цахим биржийн системээр дамжуулан нийт 13663 газрын дуудлага худалдааг амжилттай зохион байгуулаад байна. Газрын биржийн цахим системээр газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссан тоогоор газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг зохион байгуулдаг бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 3,943 газрын дуудлага худалдаа зохион байгуулсан. 3680 нь цахим хэлбэрээр, 263 нь танхимаар зохион байгуулагдсан. 1406 дуудлага худалдааг дахин зохион байгуулсан. Дуудлага худалдаанд нийт 6,672 иргэн, хуулийн этгээд оролцож, 27.1 тэрбум төгрөгийн орлогыг Улсын төсөвт төвлөрүүлсэн бөгөөд өмнөх жилтэй харьцуулахад 2 дахин нэмэгдсэн байна. | 100 | |
| 52. | 2020.03.25 №110 | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийн дэд систем болох “Газрын кадастрын мэдээллийн сангийн цахим систем”-ийг 21 аймгийн Газрын харилцаа, | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | "Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай" | барилга, хот байгуулалтын газар, 330 сумын Газрын даамал, нийслэл болон дүүргүүдийн Газар зохион байгуулалтын алба, Замын-Үүд, Цагааннуур, Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай газрын захиргааны үйл ажиллагаанд тус тус нэвтрүүлж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.<br>Мөн Газрын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, цахим шинэчлэлийн хүрээнд иргэн, хуулийн этгээд газрын эрхийн баримт бичиг болох газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ, газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ, нэгж талбарын кадастрын зургийг Газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим систем /egazar.gov.mn/-д танилт нэвтрэлтийн "Дан" системээр нэвтэрч, системээс нууцлал бүхий QR кодоор баталгаажуулж, цахим хэлбэрээр авах, нэгж талбарын дэлгэрэнгүй мэдээллийг тодорхойлолт хэлбэрээр цахимаар авах, Монгол улсын иргэнд үнэгүй газар өмчлүүлсэн эсэх лавлагаа мэдээллийг цахимаар авах, мөн 16 төрлийн газар холбоотой хүсэлтийг цахимаар тухайн шатны Газрын албанд цахимаар гаргах боломжийг бүрдүүлж, системийн хөгжүүлэлтийг хийж, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн ажиллаж байна.<br>Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийн дэд систем болох "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-ийг хэрэглээнд нэвтрүүлэн, аймгийн ГХБХБГ, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, сумын газрын даамал өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглан ажиллаж байна. Одоогийн байдлаар нийслэл, сум, дүүргийн 2019-2021 газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг системд бүрэн оруулж, кадастр, цахим биржийн системээр дамжуулан төлөвлөлтийн дагуу газар олгох ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2021 оны 9 сарын байдлаар системд 1700 газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн баримт бичиг цахим хэлбэрээр байршиж, хэрэгжиж байна.<br>Газар зүйн нэр төрлийн 18 стандартын төслийг 2021 оны 05 дугаар сарын 11-нд зохион байгуулагдсан Газрын шинэтгэлийн үндэсний хорооны 5 дугаар хурлаар хэлэлцүүлж, хурлаас үүрэг болгосон хугацаанд батлуулах шийдвэр гарсан. Дээрх стандартын төслүүдийг батлуулах үүрэг бүхий Стандарт хэмжил зүйн газартай хамтарсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын А/110 тоот тушаалаар батлуулж, ажлын хэсгийн байгуулж стандартын төсөлд санал авсан. Энэхүү стандартад санал авахаар Стандарт хэмжил зүйн газраас 71 байгууллага руу 1/307, тус газраас нийт 49 байгууллагууд руу 1/1067 албан тоот бичиг тус тус хүргүүлж, нийт албан бичиг илгээсэн 120 байгууллагаас 47 байгууллага саналгүй, дэмжиж байгаа болохоо илэрхийлсэн (утсаар болон цахим шуудангаар). Нийт 26 байгууллагаас санал ирсний дагуу саналын товчоог хамаарах стандарт тус бүр дээр гаргасан. Ирүүлсэн саналын дагуу холбогдох санал, зөвлөмж, найруулга зэргийг тусгасан. Дээрх асуудлын хүрээнд Газрын даргын даргын А/110 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг дундаа цахим хэлбэрээр /googledoc/ файл нээж, түүгээр дамжуулан шүүлт хийн стандарт боловсруулагч талтай зөвшилцөн стандартын төслийг эцэслэн боловсруулсан. 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Техникийн Хороогоор хэлэлцүүлж, Стандарт хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн С/36 тоот тушаалаар батлуулсан. | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Мөн Газрын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, цахим шинэчлэлийн хүрээнд иргэн, хуулийн этгээд газрын эрхийн баримт бичиг болох газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ, газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ, нэгж талбарын кадастрын зургийг Газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим систем /egazar.gov.mn/-д танилт нэвтрэлтийн "Дан" системээр нэвтэрч, системээс нууцлал бүхий QR кодоор баталгаажуулж, цахим хэлбэрээр авах, нэгж талбарын дэлгэрэнгүй мэдээллийг тодорхойлолт хэлбэрээр цахимаар авах, Монгол улсын иргэнд үнэгүй газар өмчлүүлсэн эсэх лавлагаа мэдээллийг цахимаар авах, мөн 16 төрлийн газар холбоотой хүсэлтийг цахимаар тухайн шатны Газрын албанд цахимаар гаргах боломжийг бүрдүүлж, системийн хөгжүүлэлтийг хийж, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. | | |
| **Ерөнхий Сайдын захирамж** | | | | |
| 1 | 2023.04.11-70 Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, замын хөдөлгөөний нягтралыг сарниулах авто замын сүлжээг бий болгож, түгжрэлийг бууруулах, хот тохижилтыг сайжруулах арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх "Сэлбэ сэргэлт" төслийг ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар ханган ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. | Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, замын хөдөлгөөний нягтралыг сарниулах авто замын сүлжээг бий болгож, түгжрэлийг бууруулах, хот тохижилтыг сайжруулах арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх "Сэлбэ сэргэлт" төслийг ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар ханган ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулагдсан. Ажлын хэсэгт тус газрын дарга орж ажиллаж байна.<br>Ажлын хэсгийн ажлын удирдамж, төлөвлөгөө батлан хэрэгжүүлж, "Сэлбэ сэргэлт" төслийг хэрэгжүүлэх газрын хэмжээ, хил зааг, замын чигийг тогтоох асуудлыг 2023 оны 2 дугаар улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Ажлын хэсгийн дарга Ц.Даваасүрэнд даалгасан.<br>"Сэлбэ сэргэлт" төслийн хүрээнд зам барих талбайн солбилцолыг холбогдох байгууллагуудтай зөвшилцөн Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл бэлтгэн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр болсон.<br>"Сэлбэ сэргэлт" төслийг болон бусад шаардлагатай төслүүдийг Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичигт тусган шинэчлэх боловсруулалтын ажлыг нийслэлийн "Хот төлөвлөлт судалгааны институт" ОНӨҮГ тай хамтран 2023 оны 6 сард багтаан дуусгахаар ажиллаж байна. | 30 | |
| 2 | 2023.04.03-62 Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай | Газрын даргаас олгогдсон итгэмжлэлийн хүрээнд захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд иргэн Э.Ганхөлөгийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт холбогдох тайлбар хүргүүлсэн. Шүүх хуралдаан болон газрын даргад шаардлагатай мэдээллийг тухай бүр гарган ажиллаж байна. нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд иргэн Т.Орхоны нэхэмжлэлтэй хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон хариу тайлбарыг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. | 100 | |
| 3 | 2022 оны 01 дүгээр Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, хөгжлийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай | **3.2.** Боомтыг хөгжүүлэх хөгжлийн хэсэгчилсэн төлөвлөгөөг боловсруулах, тодотгох ажлыг зохион байгуулах:<br>**Хэрэгжилт:** Баян-Өлгий аймгийн Цагааннуур чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг "Инженер геодези" ХХК, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотголыг "Идеал групп" ХХК боловсруулж байна. Ерөнхий төлөвлөгөөний суурь судалгааны ажлын М1:1000-ны масштабтай байр зүйн зураглал, Инженер-геологийн судалгааг орон нутагт хийж гүйцэтгэн | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тайланг боловсруулан Улсын магадлалын дүгнэлт гаргуулан Газрын архивт хүлээн авсан. | | | |
| 4 | 2022.03.04 №03<br>Цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай | Тус ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>1. Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолоор үйл ажиллагаанд нэвтэрсэн "Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем" болон түүний иргэд олон нийтэд зориулсан www.egazar.gov.mn цахим системд нэмэлт хөгжүүлэлтийг хийн газар холбоотой 27 үйлчилгээг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран авах боломжийг нэвтрүүлсэн.<br>2. Төрийн үйлчилгээний нэгдсэн платформ E-Mongolia цахим системд газрын харилцаатай холбоотой иргэдэд зориулсан 9, аж ахуйн нэгж байгууллагад зориулсан 30 нийт 39 үйлчилгээг холбож хэрэглээнд нэвтрүүлсэн.<br>3. Газартай холбоотой бүтээгдэхүүн үйлчилгээг иргэд олон нийтэд түргэн шуурхай, ил тод хүргэх зорилгоор Газрын харилцааны бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд нэг цэгээс хүргэх ухаалаг төхөөрөмж /киоск/-ийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлын даалгаврыг батлуулж нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудад хүргүүлсэн ба ухаалаг төхөөрөмж /киоск/-ийг хөгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.<br>4. "Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль"-ийн 31.1 дэх хэсэгт заасны дагуу 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Хэрэглэгчийн хурууны хээ уншигч төхөөрөмжүүд болон дуудаж ажилладаг сервисүүдийг зогсоосон. Мөн салбарын мэдээлэл технологийн журамд өөрчлөлт оруулсан. Гарын хурууны хээ агуулж байгаа систем, тоног төхөөрөмжийн техникийн мэдээлэл болон агуулж буй файл, өгөгдлийн баазыг устгаж тухайн ажлын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 1/818 дугаартай албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.<br>5. Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтарч нийт албан хаагчдын иргэний үнэмлэхийн чипэнд тоон гарын үсэг суурьлуулах ажлыг зохион байгуулсан.<br>6. И-Монгол Академитай хамтран Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар болон Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын нийт 200 гаруй албан хаагчдад "Төрийн албан хаагчдын цахим засаглалын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх" сургалтыг 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулсан.<br>7. Үндэсний орон зайн өгөгдлийн цахим систем Геопортал /www.nsdi.gov.mn/-д бусад байгууллагуудын хандах боломжийг нэмэгдүүлэх, эрхийн зохицуулалтыг оновчтой зохион байгуулах зорилгоор системийн нэмэлт хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэн хэрэглээнд нэвтрүүлсэн. Үүнд, нийт хэрэглэгчийг 4 түвшинд ангилан харгалзах эрхийн зохицуулалтыг хийсэн ба тухайн эрхийн хуваарьлалтыг шинэчлэн зохион байгуулах боломжтой болгосон. Үүний дагуу Орон зайн өгөгдлийн дэдийн систем Геопортал-д 2022 оны жилийн эцсийн байдлаар 4 түвшинд нийт 371 хэрэглэгчийг бүртгэсэн. | 100 | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5 | 2022.07.28 №07<br>Нийслэлийн цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх, 2022-2023 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай | Нийслэлийн цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх, 2022-2023 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлын хүрээнд сургууль, цэцэрлэгийн байршил, холбогдох мэдээлэл, судалгааг БХБЯ-нд гаргаж өгсөн. | 100 | Хэрэгжиж дууссан заалт тул хяналтаас хасуулах саналтай |
| 6 | 2021.06.24 №112<br>“Ажлын хэсэг байгуулах тухай” Эрдэнэбүрэнгийн 90 мВт-ын хүчин чадал бүхий “Усан цахилгаан станц барих төсөл”-ийг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг | 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Газрын шуурхай хуралд Эрдэнэбүрэнгийн УЦС барих газар орчмын нөлөөлөлд өртөж байгаа газрын судалгааг гаргаж Газрын удирдлагад танилцуулсан. 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдөр БХБЯ, Баян-Өлгий, Увс аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, УЦС-ын төсөл хэрэгжүүлэгч нартай цахим уулзалт хийж, багийн төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хэрхэн боловсруулах, байршлыг хэрхэн сонгох, хөрөнгө санхүүжилтийг шийдвэрлэх асуудлаар уулзалт хийсэн.<br>Увс аймгийн ИТХ-ын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 7/06 тоот тогтоолоор Өмнөговь сумын Улиаст багийн төвийг Рашаантын хотгорт 48 га газарт байршил шилжүүлэх асуудлыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тодотголоор оруулж баталсан.<br>Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн газарт нөлөөлөлд орсон Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Цэцэгт багийн, Увс аймгийн Өмнөговь сумын Улиаст багийн төвүүдийг шилжүүлэн байршуулахаар сонгосон газруудад багийн төвийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврын төслийг боловсруулан холбогдох газруудтай зөвшилцөн холбогдох аймгийн Засаг даргаар батлагдсан.<br>Тус газрын 2021 оны 05 сарын 12-ны 1/919 тоот албан бичгээр ажлын хэсэгт орж ажиллах албан тушаалтны нэрийг хүргүүлсэн. Тусгай хэрэгцээний газрын гэрчилгээ олгож, ажлын хэсгийн хуралд оролцож, зөвлөмж, саналыг тусгуулсан. Төсөлд шаардлагатай мэдээ мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна.<br>Батлагдсан ерөнхий төлөвлөгөө боловсруулах даалгаврын дагуу багийн төвийг нүүлгэн байршуулахаар сонгосон газрын дэвсгэр зургийн хэмжилт судалгааны ажил хийгдэж, багийн төвийн ерөнхий төлөвлөгөөний төслүүдэд улсын экспертиз хийх ажил хийгдэж байна. | 100 | |
| 7 | 2021.06.28-ны өдрийн №113<br>“Гашуун сухайт-Ганцмод” төмөр замын боомтын хилийн нэвтрэх хэсгийг Хятадын талтай тохиролцох ажлыг зохион байгуулах үүрэг бүхий “Ажлын хэсэг” байгуулах тухай | Энэ ажлын хүрээнд БОАЖЯ-ны төлөөлөл, Газар зохион байгуулалтын хэлтэс, Смарт эко транс ХХК-тай уулзалт хийсэн. БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын удирдамжаар Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах газрын байршлыг тогтоох ажлыг 2022 оны 3 дугаар сарын 25-26-ны өдөр хийсэн.<br>Засгийн газрын 2022 оны 95 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, газрын байршил, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицол, талбайн хэмжээг тогтоосон мэдээллийг ГЗБГЗЗГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 1/594 тоот албан бичгээр Барилга, хот байгуулалтын Сайдад хүргүүлсэн. | 100 | |
| 8 | 2021.03.31 №85<br>Сансрын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн батлах тухай | Сансрын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм, 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2022 оны 02 сард санал өгөв. Монгол Улсын Ерөнхий Сайдын 2022.04.04-ний өдрийн 48 дугаар захирамжаар Сансрын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг баталж, Сансрын үндэсний зөвлөлийн дарга Сансрын үндэсний зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | "Төрөөс сансар судлалын талаар баримтлах бодлого"-ийн төсөл боловсруулан, Засгийн газрын яам, агентлагаас санал авав. Баримт бичгийн төсөлд ирүүлсэн саналыг тусган сайжруулж батлуулахаар ажиллаж байна. | | |
| **Ерөнхий сайдын албан даалгавар** | | | | |
| 1 | 2023.04.17 №01<br>"Шил" ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байхаар заасан.<br>Мөн Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолоор 2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан авлигатай таван үйл ажиллагааны "Шил" ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар батлагдсан.<br>Энэ хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яамны /mddc.gov.mn/ цахим хуудаст байршуулсан 98 төрлийн мэдээллээс Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хамааралгүй 20 мэдээлэл, хуулийн хугацаа болоогүй 2 мэдээлэл, нийтэд ил тод болгох боломжгүй 1 мэдээлэл байна.<br>Байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулсан ил тод, нээлттэй байдлын тайланг загварын дагуу гаргаж 2023 оны 5 сарын 12-ны өдрийн 1/990 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Шилэн системд байрших Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.6.11 дэх заалтад заасан мэдээлэл болох Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2008 оноос хойш гаргасан дүгнэлтийг нэгтгэж ирүүлэх ажлын хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 1/949 дугаар албан бичгийг 21 аймгийн ГХБХБГ-т судалгааны маягтын хамт илгээсэн. Тус ажлын хэрэгжилтийг хангахдаа дотоод нөөц боломжоог бүрэн дайчлах, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах талаар 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр 21 аймгийн ГХБХБГ-тай цахимаар хуралдаж, цаг тухайд нь шаардлагатай мэдээлэл чиглэлийг өгсөн. Нийт 21 аймгийн улсын комиссын 4761 дүгнэлтийн мэдээллийг БХБЯ-д хүргүүлсэн.<br>Хот байгуулалт болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан 2008 оноос хойших шийдвэрийн талаарх мэдээллийг нэгтгэх ажлын хүрээнд маягтыг боловсруулан 2023 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 1/1063 дугаар албан бичгээр 21 аймгийн ГХБХБГ-т хүргүүлсэн. 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Орхон, Сүхбаатар, Хэнтий гэх нийт 10 аймаг мэдээлэл албан бичгээр ирүүлээд байна. | 90 | |
| **Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | |
| 1 | 2023.09.26-39<br>2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 39 дүгэр тэмдэглэл | Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлд "Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх, гэр хорооллыг орон сууцжуулж барилгажуулах" талаар санал хүргүүлж, 4 дүгээр бүлэгт тусгуулсан. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 9. Бүтээн байгуулалтын хүрээнд хийгдэх төсөл, арга хэмжээний газар чөлөөлөх зардлыг шийдвэрлэх зохицуулалтыг боловсронгуй болгох, газар чөлөөлөх зардлыг туха бүр тооцоолон тухайн төсөл, арга хэмжэний төсөвт зардлын хамт танилцуулж байх, төсөл арга хэмжээний явцад газрын байршлыг өөрчлөхгүй, баыхад анхаарч, хяналт тавьж ажиллах. | Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төвлөрлийг сааруулах зорилгоор хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Засгийн газрын шийдвэрийн дагуу улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн иргэн, аж ахуйн нэгжид олгосон газрыг чөлөөлнө.<br>Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөхөд нөхөх олговрын хэлбэр, газрын нөхөх олговрын үнэлгээ, газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж байгаа иргэн, хуулийн этгээдийн газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ хийх эрх бүхий этгээд, хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан байршил буюу дэд төв түшиглэн гэр хорооллыг тэргүүн ээлжид орон сууцжуулах, орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ нийгмийн суурь үйлчилгээ болох соёл, боловсрол, эрүүл мэнд, нийтийн үйлчилгээг цогц байдлаар төлөвлөж хэрэгжүүлэх, гэр хорооллыг орон сууцжуулахад төрөөс үзүүлэх дэмжлэг, санхүүжилт, гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгчийн чиг үүргийн талаар тодорхой тусган, эрх зүйг орчин бий болгохоор тусгасан. | | |
| 2 | 2023.7.26-30<br>ҮII.5 Хот хөдөөгийн сэргэлт, газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн Үндэсний хороо байгуулах, хороог ажлын албатай байхаар тооцож, шаардагдах зардлыг зохих журмын дагуу тусгах арга хэмжээ авах.<br>Засгийн газрын хэрэгжүүлэг агентлаг-Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллуулах асуудлыг шийдвэрлэх хүртэл хугацаанд шинээр газар олгохгүй байх. | Газрын багц хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг эцэслэн боловсруулах үүрэг бүхий 5 ажлын хэсгийг газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/159 дүгээр тушаалаар байгуулсан. Газрын багц хуулийн төслийг УИХ-ын 2023 оны намрын ээлжит чуулган өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх даалгаврын хүрээнд Газрын багц хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг эцэслэн болосвруулж, засгийн газарт өргөн барих үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулж өгөх талаар Барилга, хот байгуулалтын сайдад 2023 оын 09 дүгээр сарын 21-ний өдөр 1/1956 тоот албан бичгийг хүргүүлсэн. Газрын багц хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл бэлэн болсон.<br>Агентлагийн чиг үүрэг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжих болсонтой холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл, танилцуулга, дагаж өөрчлөгдөх Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газрын тогтоолын төслүүдийг тус тус боловсруулж, Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Улаанбаатар хотын хэмжээнд шинээр газар олгох ажлыг цахим системийн хэмжээнд түр хугацаагаар зогсоосон. | | |
| 3 | 2022_16. 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл<br>ХYIII.1.2. Тулгуурт байгууламж бүхий нийтийн тээврийн үйлчилгээ нэвтрүүлэх болон | Нийслэлийн Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт 110.06 га газрыг Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.13-т заасан зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулж байна.<br>Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоолоор батлагдсан “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ заагийг тогтоох, ашиглах журам”-ын 3.9.7-д | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 9. Бүтээн байгуулалтын хүрээнд хийгдэх төсөл, арга хэмжээний газар чөлөөлөх зардлыг шийдвэрлэх зохицуулалтыг боловсронгуй болгох, газар чөлөөлөх зардлыг туха бүр тооцоолон тухайн төсөл, арга хэмжэний төсөвт зардлын хамт танилцуулж байх, төсөл арга хэмжээний явцад газрын байршлыг өөрчлөхгүй, баыхад анхаарч, хяналт тавьж ажиллах. | Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төвлөрлийг сааруулах зорилгоор хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Засгийн газрын шийдвэрийн дагуу улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн иргэн, аж ахуйн нэгжид олгосон газрыг чөлөөлнө.<br>Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөхөд нөхөх олговрын хэлбэр, газрын нөхөх олговрын үнэлгээ, газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж байгаа иргэн, хуулийн этгээдийн газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ хийх эрх бүхий этгээд, хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан байршил буюу дэд төв түшиглэн гэр хорооллыг тэргүүн ээлжид орон сууцжуулах, орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ нийгмийн суурь үйлчилгээ болох соёл, боловсрол, эрүүл мэнд, нийтийн үйлчилгээг цогц байдлаар төлөвлөж хэрэгжүүлэх, гэр хорооллыг орон сууцжуулахад төрөөс үзүүлэх дэмжлэг, санхүүжилт, гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгчийн чиг үүргийн талаар тодорхой тусган, эрх зүйг орчин бий болгохоор тусгасан. | | |
| 2 | 2023.7.26-30<br>YII.5 Хот хөдөөгийн сэргэлт, газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн Үндэсний хороо байгуулах, хороог ажлын албатай байхаар тооцож, шаардагдах зардлыг зохих журмын дагуу тусгах арга хэмжээ авах.<br>Засгийн газрын хэрэгжүүлэг агентлаг-Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллуулах асуудлыг шийдвэрлэх хүртэл хугацаанд шинээр газар олгохгүй байх. | Газрын багц хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг эцэслэн боловсруулах үүрэг бүхий 5 ажлын хэсгийг газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/159 дүгээр тушаалаар байгуулсан. Газрын багц хуулийн төслийг УИХ-ын 2023 оны намрын ээлжит чуулган өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх даалгаврын хүрээнд Газрын багц хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг эцэслэн болосвруулж, засгийн газарт өргөн барих үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулж өгөх талаар Барилга, хот байгуулалтын сайдад 2023 оын 09 дүгээр сарын 21-ний өдөр 1/1956 тоот албан бичгийг хүргүүлсэн. Газрын багц хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл бэлэн болсон.<br>Агентлагийн чиг үүрэг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжих болсонтой холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл, танилцуулга, дагаж өөрчлөгдөх Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газрын тогтоолын төслүүдийг тус тус боловсруулж, Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Улаанбаатар хотын хэмжээнд шинээр газар олгох ажлыг цахим системийн хэмжээнд түр хугацаагаар зогсоосон. | | |
| 3 | 2022_16. 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл<br>XYIII.1.2. Тулгуурт байгууламж бүхий нийтийн тээврийн үйлчилгээ нэвтрүүлэх болон | Нийслэлийн Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт 110.06 га газрыг Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.13-т заасан зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулж байна.<br>Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоолоор батлагдсан “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ заагийг тогтоох, ашиглах журам”-ын 3.9.7-д | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Хотын шинэ тойрог зам төслийн бүтээн байгуулалтын явцын нөлөөлөлд өртөх нэгж талбайн нүүлгэн шилжүүлэлт, газар чөлөөлөлтөд шаардагдах хөрөнгийн тооцоо, төслийн бүтээн байгуулалтад ашиглах газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг судлан 2022 оны 4 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх | заасны дагуу НИТХ-ын саналыг авч 2022 оны 39 дүгээр тогтоолоор тус газрыг улсын тусгай хэрэгцээнд авахыг дэмжсэн.<br>Дээрх 110.06 га газрын хил заагт 35 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар нөлөөлөлд өртөж байгаа бөгөөд 21 иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь байршил шилжүүлэхийг зөвшөөрсөн, 9 аж ахуйн нэгж, байгууллагыг газарт нөхөн олговрын урьдчилсан үнэлгээг тооцоо гаргасан, 5 нэгж талбар БОАЖЯ-наас газар ашиглуулсан, зохих журмын дагуу дүгнэлт боловсруулан Барилга, хот байгуулалтын яаманд 2022 оны 11 сарын 22-ний өдрийн 1/2210 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | | |
| 4 | 2021_59. 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр 59 дүгээр тэмдэглэл<br>XIII.4.4. “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн ашиглаж буй нийслэлийн нутаг дэвсгэр дэх төмөр замын зурвас газар, барилга байгууламжийн доорх газрын асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэж дуусгах | Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн “Нийслэлийн нутаг дэвсгэр дээр байрлах Монгол-Оросын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам нийгэмлэгийн ашиглаж буй төмөр замын зурвас газар, зурвас газрын гадна байрлах барилга байгууламжийн доорх газрын асуудлыг шийдвэрлэх” тухай 101 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан.<br>Ажлын хэсгийн ээлжит хуралдаанаар Улаанбаатар хотын төмөр замын хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоохоор Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгээс ирүүлсэн саналыг хэлэлцэж, тус зурвас газарт шинээр байр зүйн зураг хийлгэж, нарийвчилсан судалгаа гаргасны дараа Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн төмөр замын хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох тухай дүгнэлт гаргасан байдаг.<br>Дээрх ажлын хэсгийн шийдвэрийг үндэслэн төмөр замын зурвас газарт 2022 оны 01 дүгээр улиралд багтаан байр зүйн зураг хийлгэж Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд ирүүлэх тухай 2021, 2022 онд тус тус 2 удаа албан мэдэгдэл хүргүүлсэн боловч тус албанд хариу хүргүүлээгүй болно. | 90 | |
| 5 | 2022_99. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай<br>2. Монгол наадам үндэсний спорт цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах арга хэмжээ авч ажиллах | “Монгол наадам үндэсний спорт цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”-ний тайлбар бичиг, зураглалын альбом, бусад холбогдох материалыг Нийслэлийн “Хот байгуулалт хөгжлийн газар”-аас акт үйлдэн авч, “Монгол наадам спорт цогцолбор” ОНӨТҮГ-т хүлээлгэн өгсөн. Батлагдсан баримт бичгийг бүрдэлийн дагуу шаардлагатай мэдээллийг “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-д оруулах тухай 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 1/1935 тоот албан бичгийг “Монгол наадам спорт цогцолбор” ОНӨТҮГ-т хүргүүлсэн бөгөөд ирүүлсэн мэдээллийг тухай бүр цахим системд оруулан ажиилаж байна.<br>Цаашид “Монгол наадам үндэсний спорт цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг Монгол наадам спорт цогцолбор” ОНӨТҮГ хариуцан ажиллана.<br>Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 24 цогцолборын барилга, байгууламжаас “Цэнгэлдэх хүрээлэн”, “Цанын бааз”-ын ажлын зураг төсөл боловсруулагдаж байгаа бөгөөд мэргэжил арга зүй, удирдлагаар ханган ажиллаж байна. | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6 | 2022_34. 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл XII.1. . "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авахыг Засгийн газрын холбогдох гишүүд, албан тушаалтанд даалгав: 1. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн шинэчлэн хэрэгжүүлэх "Монгол ган" цогцолбор I төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай газрыг улсын тусгай хэрэгцээнд авах талаар холбогдох арга хэмжээ авах | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаас 2022 оны 09 дүгээр сарын 15-ны 01/2468 дугаартай албан бичгээр "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн ган төмөрлөгийн цогцолбор үйлдвэрийг байгуулахад шаардагдах Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт орших 85.11 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах хүсэлт ирүүлсэний дагуу Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоолоор батлагдсан "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ заагийг тогтоох, ашиглах журам"-ын 3.9.7-д заасны дагуу харьяалах орон нутгийн саналыг авахаар Дархан-Уул аймгийн Засаг даргад албан бичиг хүргүүлсэн. Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдсэн бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр товлогдсон. Дэмжигдсэн саналыг хүлээн авч журмын дагуу дүгнэлтийг гарган Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | 90 | |
| 7 | 2022 оны 124/14 Газрын мониторингийн үр дүнгээр улсын хэмжээнд бэлчээрийн даац хэтэрсэн газрын төлөв байдал, ашиглалтад орон зайн дүн шинжилгээ хийж, шинээр хөв цөөрөм, худаг гаргах асуудлыг судалж, шийдвэрлэх | Засгийн газрын хуралдаанаас гарсан тэмдэглэлийг хэрэгжүүлэх зорилгоор 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 10 цагт Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Батмөнхийн ажлын өрөөнд тус яамны мэргэжилтэн Д.Мөнхгэрэл, Усны газрын дарга Ш.Мягмар, Усны газрын Ус ашиглалтын хэлтсийн дарга Б.Дарханчимэг, ГЗБГЗЗГ-ын ахлах мэргэжилтэн Г.Мөнхзул, Г.Анхбаяр нарын бүрэлдэхүүнтэйгээр хуралдсан.<br>Тухайн хурлаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд дурьдсан холбогдох байгууллагуудаас бүрдсэн ажлын хэсгийг ХХААХҮ-ийн Сайдын тушаалаар байгуулж, хийгдэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан батлуулахаар шийдвэрлэсэн. Ажлын хэсэг байгуулах тушаалын болон төлөвлөгөөний төслийг ХХААХҮЯаман дээр боловсруулан, санал авч байна. | 100 | |
| 8 | 2022.08.03-ны өдрийн 39 дүгээр хуралдаан 1.5. Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 467 км авто замын бүтээн байгуулалтын талбайтай давхцал бүхий газрын асуудлыг шийдвэрлэх | Тэмдэглэлийн дагуу Барилга, хот байгуулалтын Сайдаар ахлуулсан "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалын төсөл, гишүүдийн нэрсийн хамт 2022 оны 08 сарын 16-ны өдрийн 1/1548 албан бичгээр БХБЯ-нд хүргүүлсэн. "Боомтын орчмын газрын газар ашиглалт, төлөвлөлтийн талаарх судалгаа"-г гарган БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад 09 дүгээр сарын 07-ны өдөр танилцуулсан. Тухай бүр БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад танилцуулан, холбогдох чиглэлийг аван ажиллаж байна. | 100 | |
| 9 | 2022 оны 124/14 Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах тухай | Энэ ажлын хүрээнд БОАЖЯ-ны төлөөлөл, Газар зохион байгуулалтын хэлтэс, Смарт эко транс ХХК-тай уулзалт хийсэн. БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын удирдамжаар Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах газрын байршлыг тогтоох ажлыг 2022 оны 3 дугаар сарын 25-26-ны өдөр хийсэн. | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Засгийн газрын 2022 оны 95 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, газрын байршил, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицол, талбайн хэмжээг тогтоосон мэдээллийг Газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 1/594 тоот албан бичгээр Барилга, хот байгуулалтын Сайдад хүргүүлсэн. | | |
| 10 | 2021.10.27<br>“Агентлагын дарга нарт” | Газрын албан хаагчдыг PCR болон түргэвчилсэн шинжилгээнд тус бүр 2 удаа хамруулсан. Вакцины 1 дүгээр тунд 91 албан хаагчийг хамруулж, Вакцины 2 дугаар тунд 89 албан хаагчийг хамрагдаж, 3 дугаар тунд 16 албан хаагч хамрагдаад байна. 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 05 дугаар сарын 08-ны өдөр хүртэлх хугацаанд нийт албан хаагчдын 10%, 05 дугаар сарын 08-ны өдрөөс 06 дугаар сарын 02-ны өдөр хүртэл хугацаанд 30%-ийн ирцтэйгээр ажиллаж, үлдсэн 70% ийн ажилчид цахимаар ажилласан бөгөөд БХБЯамны Төрийн нарийн бичгийн даргаас ирүүлсэн чиглэлийн дагуу 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 8 дугаар сарын 31-ны хооронд албан хаагчдын 70 хүртэлх хувьд ээлжийн амралт олгож биеэр эдлүүлсэн. Байгууллагын албан хаагчдыг Вакцины 3 дугаар тунд идэвхитэй хамрагдахыг уриалж ажилласан бөгөөд 10-11-р сард 56 албан хаагч хамрагдаад байна. Ковид-19 цар тахалын байгууллагын цаг үеийн мэдээг 2021 онд Барилга, хот байгуулалтын яамны шуурхай штабт өдөр бүр мэдээллэн ажилласан. 2022 онд 1 сард Коронавируст халдвар /Ковид/-ын тархалтын түвшинд үндэслэн хүн хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журмыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж газрын даргаар батлуулсан. 2022 оны 02 дугаар сарын 14 өдрөөс эхлэн Засгийн газраас цар тахлын улбар шар түвшинг шар түвшинд шилжүүлж, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг цуцалсан. | 100 | Хэрэгжиж дууссан заалт тул хяналтаас хасуулах саналтай |
| 11 | 2021.07.08<br>Засгийн газрын Агентлагын дарга нарт<br>/УИХ-ын 2020 оны 45, 2021 оны 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулан, салбарын хэмжээнд хэрэгжиж буй Үндэсний хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5-д заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлэн, ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан " Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасан хугацаанд гаргах/ | Газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулж, Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасан хугацаанд холбогдох байгууллагуудад тайлагнан ажиллаж байна. | 100 | |
| 12 | 2021.07.08 | Засгийн газрын 2021 оны 38-р хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаварын дагуу Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 07 дугаар сарын | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт /Төв аймгийн Хөшигийн хөндийн дэх шинэ хотуудын нэгдсэн төлөвлөлт /Концепци/-ийн дагуу бүсийн хөгжлийн төслийг боловсруулж, төлөвлөгөө гаргаж, арга хэмжээг авч хэрэгжүүлэх/ | 05-ны өдрийн 160 дугаар тушаал, Төв аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/422 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж, бэлтгэл ажлыг хангасан.<br>Бэлтгэл ажлын хүрээнд Төв аймгийн Алтанбулаг, Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт тусгай хэрэгцээнд авахаар төлөвлөж буй **19390.4** га газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж, өмчилж байгаа нийт **2983** нэгж талбарын **7603.7** га газар давхцалыг тодорхойлсон.<br>Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол, Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 202/196 дугаар хамтарсан тушаалаар баталсан аргачлал, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 203 дугаар тушаалыг баримтлан давхцалтай **2983** нэгж талбараас газар дээрээ үйл ажиллагаа явуулж байгаа болон үл хөдлөх хөрөнгөтэй **183** нэгж талбарт мэргэжлийн байгууллагаар урьдчилсан үнэлгээ хийлгэхэд **40.532.510.036** төгрөгийн нөхөх олговорын тооцоо гарсан.<br>Төв аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газартай хамтран зөрчилтэй болон хууль тогтоомж зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг хүчингүй болгох ажиллагааг Захиргааны ерөнхий хууль болон Газрын тухай хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Хөшигийн хөндийн 19390.4 га газарт хамаарах 3054 нэгж талбарыг чөлөөлөх ажлын төлөвлөгөөг 2022 оны 1 дүгээр сард Барилга, хот байгуулалтын Сайдаар батлуулан ажиллаж байна. Уг төлөвлөгөөний дагуу тусгай хэрэгцээнд авсан газарт 1:1000 масштабтай байрзүйн зураг, газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө хийх ажлыг зохион байгуулж дуусч байна.<br>Тусгай хэрэгцээнд авсан газарт нөлөөлөлд өртөж буй давхцалтай иргэн, хуулийн этгээдийн газрыг чөлөөлөх ажлыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга болон Төв аймгийн Засаг даргын хамтарсан ажлын удирдамжийн дагуу 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2022 оны 09 дүгээр сарын 20-ны байдлаар өмчлөгдсөн 470 нэгж талбарын байршлыг шилжүүлээд байна. 2022 онд нийт 423 нэгж талбарыг хүчингүй болгож, 470 нэгж талбарыг байршил шилжүүлж, 64 нэгж талбарыг хүчингүй болгохоор мэдэгдэл хүргүүлээд байна.<br>Барилга, хот байгуулалтын Сайдын 2021 оны 270 дугаар тушаалаар батлагдсан Улсын тусгай хэрэгцээнд авсан газартай давхцалтай иргэн, хуулийн этгээдийн газрыг чөлөөлөх ажлын хэсгийн 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрээр Улсын тусгай хэрэгцээний газарт ерөнхий төлөвлөгөө хийж байгаатай холбогдуулан Сэргэлэн суманд нөлөөлөлд өртсөн эзэмшлийн нэгж талбаруудын байршил шилжүүлэхээр санал болгож ирүүлсэн газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон байр зүйн зураг зохиох ажлын даалгавар, холбогдох тооцоо, хэрэгжүүлэх зөвлөмж, нөлөөлөлд өртсөн нэгж талбарыг чөлөөлөх ажлын хүрээнд зуслангийн зориулалтаар газар эзэмшиж байгаа иргэдийн газрыг нүүлгэн шилжүүлэж, байршуулах газрыг сонгох, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгах ажлыг зохион байгуулах ажлын чиглэлийг орон нутгийн ГХБХБГ-т хүргүүлсэн.<br>БХБЯ-ны захиалгаар "Олон улсын шинэ нисэх онгоцны "ЧИНГИС ХААН" буудлыг түшиглэн бий болох шинэ хотуудын инженерийн дэд бүтцийн хангамжийн судалгаа, эх үүсвэрийг тодорхойлох" зөвлөх үйлчилгээний ажлыг нийслэлийн "Хот төлөвлөлт судалгааны институт" ОНӨҮГ гүйцэтгэн улсын магадлалд хянуулж байна. | | |
| 13 | 2021.06.21<br>Агентлагын дарга нарт<br>/Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааг олон нийтэд түгээх, төвийн цахим програм хангамжийг бүрэн ашиглах, иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг мэдээлэх, | Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөс 2022 оны 01 дүгээр сарын 02—ны өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт 67 өргөдөл гомдол ирсэнээс 65 өргөдөл, хүсэлт ирснийг судлан хүсэлтийг хугацаанд нь хариу хүргүүлж шийдвэрлэсэн. Судалж байгаа 2 өргөдөл, хүсэлтийг судлан, хугацаанд нь хариу хүргэн шийдвэрлэхээр ажиллаж байна. Үүнээс 5 хоногт хариу өгсөн 55, 10 хоногт хариу өгсөн 6, 15 хоногт хариу өгсөн 6 өргөдөл, хүсэлт байна. | 100 | |
| 14 | 2021.06.01<br>Салбарын дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулж, Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасан хугацаанд холбогдох байгууллагуудад тайлагнан ажиллаж байна. | 100 | |
| 15 | 2021.04.14 №24<br>Монгол улсын Газрын нэгдмэл сангийн 2020 оны тайлангийн талаар | Иргэд олон нийтэд зориулсан Egazar.gov.mn цахим системийг хөгжүүлж Газрын төлбөр, татварын системтэй холбосноор газрын төлбөр, татвартай холбоотой мэдээллийг авах, нэхэмжлэхийн дагуу төлөх, тус системээр дамжуулан иргэд, олон нийт төлбөр, татварын тооцоо нийлсэн актыг цахимаар авах боломжийг бүрдүүлсэн байна. Мөн Ebarimt төлбөрийн цахим системээр дамжуулан газрын төлбөр, татвараа төлөх боломжтойгоос гадна Улсын тэмдэгтийн хураамж, Үйлчилгээний хураамжийг тус төлбөрийн цахим системээр дамжуулан төлөх боломжтой болсон. Тус үйлчилгээний сервисүүдийг E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн системтэй холбосноор дээрх бүх үйлчилгээнүүдийг уг системээс авах боломжтой болсон. | 100 | |
| 16 | 2021.09.29 №53<br>"Агентлагын дарга нарт" | Газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулж, Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасан хугацаанд холбогдох байгууллагуудад тайлагнан ажиллаж байна. Мөн 21 аймаг, нийслэлийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тус тогтоолын дагуу үнэлэн холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. | 100 | |
| 17 | 2021.09.15 №51<br>БОАЖЯ, Газрын газрын харилцааны салбарын мэдээллийн сан, улсын тусгай хэрэгцээнд авсан газрын | Газрын шинэтгэлийн үндэсний хорооны 2021 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах арга хэмжээний төлөвлөөнд туссан Үндэсний орон зайн өгөгдлийн геопорталыг хөгжүүлж, үйл ажиллагаанд оруулах ажлын хүрээнд орон зайн өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэгч, ашиглагч, түгээгч байгууллагуудын мэдээллийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 | 100 | Хэрэгжиж дууссан заалт тул хяналтаас |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | мэдээллийг "Орон зайн мэдээллийн сан"-д оруулах, олон нийтэд нээлттэй болгох | дугаар сарын 09-ний өдрийн С/36 тушаалаар батлуулсан суурь орон зайн 18 дэд сан бүрт зориулан өгөгдлийн үзүүлэлтийн /UML/ стандартын дагуу хөрвүүлэн дээрх геопорталд оруулах ажлын хийж гүйцэтгээд байна. Үүнд, БОАЖЯ-ны мэдээллүүд болох тусгай хамгаалалтад авсан газрын мэдээлэл "Газар ашиглалт" төрөлд хамаарч нэгдсэн мэдээллийн санд орсон болно. Ингэснээр тус байгууллагын мэдээллийн сан нь газрын харилцааны мэдээллийн сантай нэгтгэгдэн геопорталаар дамжин иргэд олон нийтэд нээлттэй болсон. | | хасуулах саналтай |
| 18 | 2021.03.31 №21<br>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн талаар | Тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Засгийн газрын 2021 оны "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 374 дүгээр тогтоолд заасны дагуу холбогдох байгууллагуудад тайлагнан ажиллаж байна. | 100 | |
| | | **Барилга, хот байгуулалтын Сайдын тушаал** | | |
| 1. | 2023.06.20-147<br>Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай | 2023 онд цахим ситемээр дамжуулан геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулах хүсэлт давхардсан тоогоор 206 ирсэн. Үүнээс:<br>- Шийдвэрлэгдсэн-77;<br>- Татгалзсан-12;<br>- Ажлын хэсэгт шилжсэн 3;<br>- Суурь нөхцөл шаардлага хангаагүй тул буцаагдсан 90;<br>- Хянагдаж байгаа 4 хүсэлт байна.<br>Барилга, хот байгуулалтын Сайдын 7 удаагийн тушаалаар 77 хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, гэрчилгээг олгосон. | 100 | |
| 2. | 2023.07.07-167<br>Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай | 2023 онд цахим системд Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх авах, эрхээ сунгуулах хүсэлт давхардсан тоогоор 119 ирсэн. Үүнээс:<br>- Шийдвэрлэгдсэн 44;<br>- Татгалзсан 7;<br>- Суурь нөхцөл шаардлага хангаагүй тул буцаагдсан 37;<br>- Ажлын хэсэгт шилжсэн 2;<br>- Хянагдаж байгаа 6 хүсэлт байна.<br>Барилга, хот байгуулалтын Сайдын 5 удаагийн тушаалаар 35 хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, гэрчилгээг олгосон. | | |
| 3. | 2023.05.08 №204<br>Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийн тусгай зөвшөөрөл шинээр олгох тухай | Эрхийн зөвшөөрлийн цахим систем https://license.mcis.gov.mn/-ээр аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч, журмын дагуу хянан, шалгаж Барилга хот байгуулалтын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 204 дүгээр тушаалаар "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ ХБ-1.1 ажлын төрлөөр эрх олгож, гэрээ байгуулан, эрхийн гэрчилгээг олгосон. | 100 | |
| 4. | 2022 оны №128<br>Ажлын хэсэг байгуулах тухай | Засаг захиргааны нэгж /баг/-ийн нэр тогтоох, УИХ-ын 2003 оны 42 дугаар тогтоолоор баталсан газар зүйн нэрийн жагсаалтыг тодотгох асуудлыг судалж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг 21 аймаг, нийслэл, яам, агентлаг, аж ахуй | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | нэгжийн төлөөлөл бүхий 43 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулагдав. Ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн даргаар батлуулав.<br>2022 оны 8 дугаар сарын 26-ны өдөр Ажлын хэсгийн анхдугаар хурлыг зохион байгуулан Ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөг танилцуулан, Багийн нэр батлах тухай УИХ-ын тогтоолын хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа, тогтоолын төслийн үзэл баримтлалын төслийг танилцуулан хэлэлцүүлэв. Ажлын хэсгийн гишүүдэд хугацаатай үүрэг даалгавар өгөв.<br>ЗГХЭГ-т 2022 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн 1/1696 дугаар албан бичгийг хүргүүлж Багийн нэр батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлүүлэхээр 4 аймагт шаардлагыг уламжлуулав.<br>2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 1/1842 дугаар албан бичгээр Багийн нэр, солбицолд санал авахаар 21 аймгийн Засаг дарга нарт хүргүүлэв.<br>Ажлын хэсгийн 2-р хурал 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулан, Ажлын хэсгийн 1-р хурлын шийдвэрийн үр дүн, Газар зүйн нэрийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, тодруулалтын ажлын явцын мэдээлэл, МУ-ын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн нэр болох багийн нэр, солбицлын жагсаалт батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалсан үнэлгээний тайлан, тогтоолын төслийн үзэл баримтлал болон тогтоолын төсөлд ирүүлсэн саналыг тус тус танилцуулав. “Багийн нэрийн жагсаалт батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалын төсөл, тандан судалгааны төсөл, тогтоолын төсөлд саналаа 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлэхийг Ажлын хэсгийн гишүүдэд даалгав.<br>Ажлын хэсгийн хурлын тэмдэглэлийг хөтөлж ГЗБГЗЗГ-ын дарга, Ажлын хэсгийн дэд даргаар баталгаажуулав.<br>Ажлын хэсгийн 3-р хурлыг 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулж, гарсан дүгнэлтийг БХБЯ-нд хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | | |
| 5. | 2022 оны №171<br>Ажлын хэсэг байгуулах тухай | “Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоо” ТББ-ын үйл ажиллагаатай танилцаж, үнэлгээ, дүгнэлт гаргах, цаашид хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг 2022.08.19-ний өдөр байгуулагдаж 2022.08.26-ны өдөр анхдугаар хурлыг зохион байгуулан Ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөний төсөл боловсруулан гишүүдээс саналыг авч тусган 2022.08.26-ны өдөр БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн даргаар батлуулав. Ажлын хэсгийн хурлын тэмдэглэлийг хөтөлж Газрын дарга, Ажлын хэсгийн дэд даргаар баталгаажуулав.<br>Барилгын тухай хууль, Авто замын тухай хууль, ЗГ-ын 2018 оны 22-р тогтоолоор батлагдсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ыг судлан, 2022.08.30-ны өдөр “Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоо” ТББ-ын үйл ажиллагаатай танилцав.<br>БХБЯ-ны 2022.09.05-ны өдрийн 3/4071 дугаар албан бичгийн дагуу “Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоо” ТББ-аас 2022.09.12-ны өдрийн 20/18 тоотоор хариуг хүлээн авч баримт, материалыг судалж байна. | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Ажлын хэсгийн 2-р хурал 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулав. Геодези, зураг зүйн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг "Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоо" ТББ-ын үйл ажиллагаанд шилжүүлэх талаар дүгнэлт гаргаж цаашид хамтран ажиллах санал боловсруулав. | | |
| 6. | 2022 оны №85 Хэмнэлтийн горимоор ажиллуулах тухай | Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны "Хэмнэлтийн горимоор ажиллуулах тухай" 85 дугаар тушаалыг 21 аймгийн ГХБХБГ болон Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбогдуулан харъяа газруудад чиглэл хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 | |
| 7. | 2021 оны №253 Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай /Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ, эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам" | 2022 онд Барилга, хот байгуулалтын Сайдын 6 удаагийн тушаалаар мэргэжлийн байгууллагын эрх шинээр авсан, сунгасан 40 хуулийн этгээдийн бүртгэлийг, 6 удаагийн тушаалаар геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, сунгасан 47 аж ахуйн нэгжийн мэдээллийн сангийн бүртгэлийг тус тус хөтөлсөн. | 100 | |
| 8. | 2021.11.18 №245 Журам батлах тухай | Эрхийн зөвшөөрлийн цахим систем https://license.mcis.gov.mn/-ээр 15 аж ахуйн нэгжийн 21 хүсэлтийг хүлээн авч хянан, Барилга, хот байгуулалтын Сайдын 5 удаагийн тушаалаар хот байгуулалтын баримт бичиг боловсруулах ХБ1-1 ажлын төрлөөр 9 аж ахуйн нэгжид, ХБ-1-2 ажлын төрлөөр 2 аж ахуйн нэгжид, ажлын төрөл давхардсан тоогоор 9 аж ахуйн нэгжид эрх олгож, гэрчилгээг гардуулан, гэрээ байгуулсан байна.<br>2022 онд 47 аж ахуйн нэгжийн эрх дуусгавар болж, цахим системээр анхааруулга хүргүүлсэн. Батлагдсан журмын дагуу олгогдсон эрхийн хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг 2022 оны 11 дүгээр 21-ны өдрийн А/191 дугаар тушаалаар байгуулж баталсан удирдамжийн дагуу уг ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>Эрхийн зөвшөөрлийн цахим систем https://license.mcis.gov.mn/-ээр 4 аж ахуйн нэгжийн 7 хүсэлтийг хүлээн авч, журмын дагуу хянан, шалгаж 3 аж ахуйн нэгжийн 6 хүсэлтийг буцаасан. Барилга, хот байгуулалтын Сайдын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01 дугаар тушаалаар "Сонголт дизайн" ХХК-д ХБ-1.1, ХБ-1.2 ажлын төрлөөр эрх олгож, гэрээ байгуулан, эрхийн гэрчилгээ баталгаажихаар хүлээгдэж байна. | 100 | |
| 9. | 2021.07.19 №160 Ажлын хэсэг байгуулах тухай | Барилга, хот байгуулалтын Сайдын 2021 оны 270 дугаар тушаалаар батлагдсан Улсын тусгай хэрэгцээнд авсан газартай давхцалтай иргэн, хуулийн этгээдийн газрыг чөлөөлөх ажлын хэсгийн 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрээр Улсын тусгай хэрэгцээний газарт ерөнхий төлөвлөгөө хийж байгаатай холбогдуулан Сэргэлэн суманд нөлөөлөлд өртсөн эзэмшлийн нэгж талбаруудын байршил шилжүүлэхээр санал болгож ирүүлсэн газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон байр зүйн зураг зохиох ажлын даалгавар, холбогдох тооцоо, хэрэгжүүлэх зөвлөмж, нөлөөлөлд өртсөн нэгж талбарыг чөлөөлөх ажлын хүрээнд зуслангийн зориулалтаар газар эзэмшиж байгаа иргэдийн газрыг нүүлгэн шилжүүлэж, байршуулах газрыг сонгох, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгах ажлыг зохион байгуулах ажлын чиглэлийг орон нйтгийн ГХБХБГ-т хүргүүлсэн.<br>“Хот суурин газрын ногоон байгууламжийн төлөвлөлт” /БД/ барилгын дүрмийн танилцуулга болон техникийн даалгаврын төслийг тус тус боловсруулан санал авахаар Барилга хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын Харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлсэн. | | |
| 10. | 2021.03.03 №44<br>Журмын хэрэгжилтийг хангах тухай | Монгол Улсын Засгийн газрын 2020 оын 04 дүгээр сарын 02 өдрийн 152-р тогтоолоор батлагдсан журмын өөрчлөлтийн хүрээнд газрын дуудлага худалдааг зохион байгуулан ажиллаж байна. Улсын хэмжээнд газрын цахим биржийн системээр дамжуулан нийт 13663 газрын дуудлага худалдааг амжилттай зохион байгуулаад байна. Газрын биржийн цахим системээр газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссан тоогоор газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг зохион байгуулдаг бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 3,943 газрын дуудлага худалдаа зохион байгуулсан. 3680 нь цахим хэлбэрээр, 263 нь танхимаар зохион байгуулагдсан. 1406 дуудлага худалдааг дахин зохион байгуулсан. Дуудлага худалдаанд нийт 6,672 иргэн, хуулийн этгээд оролцож, 27.1 тэрбум төгрөгийн орлогыг Улсын төсөвт төвлөрүүлсэн бөгөөд өмнөх жилтэй харьцуулахад 2 дахин нэмэгдсэн байна. | 100 | |
| 11. | 2019.03.26 №53<br>Журам батлах тухай | Эрхийн зөвшөөрлийн цахим систем https://license.mcis.gov.mn/-ээр 15 аж ахуйн нэгжийн 21 хүсэлтийг хүлээн авч хянан, Барилга, хот байгуулалтын Сайдын 5 удаагийн тушаалаар хот байгуулалтын баримт бичиг боловсруулах ХБ1-1 ажлын төрлөөр 9 аж ахуйн нэгжид, ХБ-1-2 ажлын төрлөөр 2 аж ахуйн нэгжид, ажлын төрөл давхардсан тоогоор 9 аж ахуйн нэгжид эрх олгож, гэрчилгээг гардуулан, гэрээ байгуулсан байна.<br>2022 онд 47 аж ахуйн нэгжийн эрх дуусгавар болж, цахим системээр анхааруулга хүргүүлсэн. Батлагдсан журмын дагуу олгогдсон эрхийн хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг 2022 оны 11 дүгээр 21-ны өдрийн А/191 дугаар тушаалаар байгуулж баталсан удирдамжийн дагуу уг ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | 100 | |
| 12. | 2019.03.26 №54<br>Журам батлах тухай | Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын Сайдын 2011 оны 226 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм”-ийг өнөөгийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах ажиллагаа хийгдэж байна.<br>Уг дүрмийн нэмэлт, өөрчлөлт оруулах Барилга, хот байгуулалтын Сайдын тушаалын төсөлд санал авхаар Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газар, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 1/1804 дугаар албан бичгийг хүргүүлж иргэд, аж ахуйн нэгжээс 2022 оны 10 дугаар сарын 15-ны дотор санал авхаар www.gazar.gov.mn, байгууллагын олон нийтийн цахим сүлжээнд байршуулсан.<br>Ирүүлсэн саналуудыг нэгтгэн Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлэн ажиллаж байна. | 100 | |
| 13. | 2023.05.08 №96<br>Ажлын хэсэг байгуулах тухай | “Барилга байгууламжийн чанарын зөвлөгөөн-2023” арга хэмжээ зохион байгуулагдах тушаал батлагдсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу салбар 4 | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | зөвлөгөөний нэг болох "Барилгын чанар, аюулгүй байдал- Паспортжуулалт" салбар зөвлөгөөний ерөнхий зохион байгуулагчаар ажиллаж 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Хөвсгөл аймгийн Мөрөн хотод амжилттай зохион байгуулсан. | | |

1. Ерөнхийлөгчийн зарлиг – 1 – 100%
2. Улсын Их Хурлын тогтоол – 2 – 100%
3. Засгийн газрын тогтоол – 52 – 92.3%
4. Ерөнхий сайдын захирамж – 8- 100%
5. Ерөнхий сайдын албан даалгавар – 1 – 97%
6. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл – 18– 98.75%,
7. БХБСайдын тушаал – 13 – 100%

**Нийт хэрэгжиж буй 95 тогтоол шийдвэр – 98.2%**

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР